



Нэгдсэн Үндэстний
Боловсрол, Шинжлэх Ухаан
Соёлын Байгууллага



ЮНЕСКО-ийн
Монголын Үндэсний
Комисс



ДЭЛХИЙН ӨВ

**МОНГОЛ АЛТАЙН НУРУУНЫ ХАДНЫ ЗУРГИЙН
ЦОГЦОЛБОР**



ДЭЛХИЙН ӨВ

МОНГОЛ АЛТАЙН НУРУУНЫ ХАДНЫ ЗУРГИЙН ЦОГ ЦОЛБОР

Улаанбаатар хот
2019

ДЭЛХИЙН ӨВ

МОНГОЛ АЛТАЙН НУРУУНЫ ХАДНЫ ЗУРГИЙН ЦОГЦОЛБОР

Эмхэтгэсэн: **Ч.Цэцэгбаатар**
Б.Энхгэрэл
Г.Анхсанаа
М.Цэцэнбилэг

Зөвлөсөн: **Н.Уртнасан**
А.Намхай
Б.Даваацэрэн

Редактор: **С.Уянга**
Г.Энхбат

Цаасны хэмжээ: 167х237

Хэвлэлийн хуудас: 6.0 хх

Хавтасны зураг: “Шивээт Хайрхан, Цэнгэл сум, Баян-Өлгий”, **Г.Ган-Өлзий**

© ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс

Энэхүү номыг ЮНЕСКО-ийн Оролцооны хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс эрхлэн гаргав.

Хамтран ажилласан байгууллагууд:



БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЙН ЯАМ



Гарчиг

Талархал	4
НЭГ. ЮНЕСКО БА ДЭЛХИЙН ӨВ	5
1.1 Өв гэж юу вэ?	5
1.2 ЮНЕСКО ба Дэлхийн өвийн конвенц	6
1.2.1 Дэлхийн соёлын өв	8
1.2.2 Дэлхийн байгалийн өв	9
1.2.3 Холимог өв	9
1.3 Дэлхийн өвийн урьдчилсан жагсаалт ба Монгол улсаас Дэлхийн өвд бүртгэгдсэн өвийн газар нутгууд	10
1.4 Дэлхийн өвийн хадгалалт хамгаалалтын менежмент	15
1.5 Монгол улсын нэгдсэн орсон ЮНЕСКО-ийн соёлын конвенцууд	18
ХОЁР. ДЭЛХИЙН ӨВ-МОНГОЛ АЛТАЙН НУРУУНЫ ХАДНЫ ЗУРГИЙН ЦОГЦОЛБОР	21
2.1 Товч танилцуулга	21
2.2 Газар зүй, байгаль, цаг уурын онцлог	24
2.3 Хамгааллын үйл ажиллагаа	26
2.4 Засаг захиргааны нэгж, байршил	28
2.4.1 Баян-Өлгий аймаг	28
2.4.2 Улаанхус сум	28
2.4.3 Цэнгэл сум	30
ГУРАВ. ДЭЛХИЙН ӨВИЙН ГАЗАР НУТАГ ДАХЬ СОЁЛЫН ӨВ	35
3.1 Угсаатны товч түүх, соёлын биет бус өв	35
3.2 Археологийн судалгааны тойм	43
3.3 Түүх, соёлын үл хөдлөх дурсгалууд	45
3.4 Түүх, соёлын хөдлөх дурсгалууд	58
ДӨРӨВ. ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖУУД	59
Хавсралт зураг	69
Ном зүй	71

Дэлхий дахинаа хэдхэн жилийн дотор байгаль, соёлын өв эргэн нөхөгдөшгүйгээр устаж үгүй болсоор байна. Ялангуяа хүрээлэн буй орчны бохирдолт, байгалийн гамшиг, дайн, ядуурал, үйлдвэржилтийн хэт өсөлтийн уршгаар та бидний эрдэнэт өв доройтон муудсаар байна. Иймд олон улсын хамтын нийгэмлэг ЮНЕСКО нь Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай конвенцыг 1972 онд баталж ховор нандин үнэт өвийг устаж үгүй болохоос урьдчилан хамгаалахад хүчин чармайлт гаргаж эхэлсэн юм.

Нэг улс орны бүтээн бий болгосон буюу эзэмшиж байгаа байгаль, соёлын өв нь дэлхий нийтийн хосгүй гайхамшигт үнэ цэнтэй байдаг учраас түүнийг хадгалан хамгаалах нь зөвхөн тухайн улсын үүрэг бус дэлхий дахинд хамааралтай байдаг.

Тухайн өвийг хадгалан хамгаалах нэгэн чухал арга зам бол өвийн талаар олон нийтэд сурталчлан таниулах, мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, судалгаа шинжилгээний олон ажлуудыг хийх, төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хувь хүмүүсийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх юм.

Иймд ЮНЕСКО-ийн дэмжлэгтэйгээр ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс нь Дэлхийн өвийн хөдөлгөөнт сургалт төслийг санаачилж, уг төслийн хүрээнд Дэлхийн өв-Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолбор номыг бэлтгэн та бүхэнд толилуулж байна. Энэхүү номыг боловсруулах ажилд бүхий л талаар туслалцаа үзүүлж хамтран ажилласан Соёлын өвийн үндэсний төв, Байгаль, орчин аялал жуулчлалын яамны Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газар, номыг бэлтгэхэд үнэт зөвлөгөө өгч хамтран ажилласан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Соёл, урлагийн бодлогын газар, Байгаль болон соёлын өвийг хамгаалах сан төрийн бус байгууллагын удирдлага, хамт олонд ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын зүгээс гүн талархал илэрхийлье.

Энэхүү ном нь дэлхийн байгалийн болон соёлын өвийн талаарх таны мэдлэг оюунд тус нэмэр болохоос гадна өөрийн нутаг дэвсгэрт буй дэлхийн өвийг хайрлан хамгаалж хойч үедээ өвлүүлэн уламжлуулах их үйлсэд одооноос эхлэн гар бие оролцоно гэдэгт бид итгэлтэй байна.

Таны байгаль, соёлын өвийг хамгаалах үйлсэд оруулж буй хувь нэмэр бидний ирээдүй хойч үеийг тэтгэн дэмжиж цогцлоон бадраах болтугай!

*ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын
Ерөнхий нарийн бичгийн дарга
С.Уянга*

1.1 ӨВ ГЭЖ ЮУ ВЭ?

Өнгөрсөн үеэс бидэнд өвлөгдөн үлдсэн, одоо бидэнд байгаа, ирээдүй хойч үе маань түүнээс суралцаж, түүнийг гайхан биширч, сэтгэлийн таашаал авч байх үүднээс ирээдүйд уламжлан үлдээж байгаа аливаа зүйлийг өв гэнэ.

“Соёлын өв” гэж түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэн, ач холбогдол бүхий өвийг хэлэх бөгөөд соёлын өвийг биет ба биет бус хэмээн хоёр ангилна.

Соёлын биет өвийг дотор нь “түүх, соёлын үл хөдлөх дурсгал” болон “түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл” хэмээн хуваадаг.

“Түүх, соёлын үл хөдлөх дурсгал” гэдэг нь гадна орчинд, байгаль дээр тухайн унаган газартаа хүрээлэн байгаа орчны хамт үнэ цэн ач холбогдол нь илэрхийлэгддэг, авран хамгаалах аюул эрсдэлээс сэргийлэх зорилгоор зөөж хөдөлгөхөөс бусад тохиолдолд хөдөлгөхийг хориглох дурсгалыг хэлдэг бол “түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл” гэж тодорхой орон зайд шилжүүлэн байршуулах боломжтой, музейн сан хөмрөг, хувь хүн, сүм хийдэд уламжлагдан, тахигдаж ирсэн, биедээ болон зөөж тээвэрлэн авч явах боломжтой эд өлгийн зүйлсийг хамаатуулж болно.

“Соёлын биет бус өв” гэж хувь хүн, бүлэг, хамт олон, угсаатан, үндэстний олон зуун жилийн түүхийн туршид бүтээн бий болгосон хэл яриа, ёс, зан заншил, уламжлалт мэдлэг, амьдрах арга ухаан, дуу хуур, хөгжим бүжиг, тоглоом наадам, гар урлалын дэг, хийц маяг зэрэг хүний оюун ухаанаар бий болсон зүйл хэмээн ойлгож болно.

Таны амьдарч буй газар нутагт байгаа эртний булш, хиргисүүр, хадны зураг бичээс, эртний хотын туурь, сүм хийдийн үлдэгдэл, аймаг, сумын музейд хадгалагдаж буй үзмэр, таны аав, ээж, эмээ өвөөгөөсөө уламжлан авч үлдсэн

эд өлгийн зүйлс болон ардын дуу, хөгжим, сүү цагаан идээгээ боловсруулах арга ухаан, таван хошуу малаа нүүдэллэн маллаж амьдрах арга ухаан энэ бүгд соёлын өв юм.

Харин та үзэсгэлэнт сайхан гол мөрөн, ой мод, ховор амьтадтай газар амьдардаг бол эдгээр нь байгалийн өв юм.

Байгаль, соёлын өв нь бидэнд өвлөгдөн үлдсэн хосгүй нандин зүйл, түүх, шинжлэх ухааны чухал ач холбогдол бүхий юугаар ч орлуулшгүй, гайхамшигт жишээ төдийгүй бидний хэн болохыг тодорхойлж байдаг нэг ёсны үндсэн таних тэмдэг юм. Өвөг дээдсийн маань амьдрал, үйл хэргийг тусган харуулдаг тул тэдгээрийг хадгалж хамгаалах гэж онцгой хүчин чармайлт тавьж ирсний үр дүнд өнөөдрийг хүртэл хадгалагдсаар байдаг билээ.

Өөрийн амьдарч буй нутаг орноо та ямар нэгэн өвгүйгээр төсөөлж чадах уу? Та өөрийн амьдарч буй газар нутгийг аваад үз. Өнгөрсөн, одоо, ирээдүйг юу төлөөлж байна вэ? Юуг нь бид хадгалж хамгаалах ёстой, юуг нь нөхөн сэргээж болох вэ?

Бидний соёлын болон байгалийн өв нь маш эмзэг бөгөөд ялангуяа сүүлийн 100 гаруй жилд сөнөж мөхөхийн аюултай байнга тулгарч байна. Жишээ нь: Дэлхийн I, II дайны жилүүдэд эртний том, жижиг олон хот суурин устаж, чухал соёлын хөшөө дурсгалууд сүйрч үгүй болсон. Түүнчлэн бидний өв хотжилт, ядуурал, байгалийн гамшиг болон хүрээлэн буй орчны бохирдолт зэргээс шалтгаалан мөн л мөхлийн аюулд тулгараад байна. Өвийг хадгалж үлдээхэд учирч байгаа нэг томоохон аюул бол хүмүүсийн байгаль дэлхийтэйгээ зүй бусаар, хайхрамжгүй харьцаж буй явдал юм.

1.2 ЮНЕСКО БА ДЭЛХИЙН ӨВИЙН КОНВЕНЦ

Нэгдсэн Үндэстний Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага буюу ЮНЕСКО нь дайнаас урьдчилан сэргийлэх, түүнээс үүдэх хохирлыг багасгахад хүчин чармайлтаа чиглүүлдэг ба боловсрол, шинжлэх ухаан, соёл, үндэстэн угсаатны хамтын ажиллагаанд тулгуурлан энх тайван, аюулгүй байдлыг тогтооход хувь нэмрээ оруулахыг эрхэмлэдэг байгууллага юм.

Энэхүү байгууллага нь “хүн төрөлхтний оюун санаа, ёс суртахууны эв нэгдэл”-ийг хангаж, дэлхийд дайн өдөөхгүй байх, боловсрол, шинжлэх ухаан, соёл, байгаль орчин, хэвлэл мэдээллийн олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлж, ирээдүйд чиглэсэн бодлого, үйл ажиллагааны стратеги дэвшүүлэн хүн төрөлхтний дэвшил хөгжлийг урагшлуулах зорилготой. ЮНЕСКО нь олон улсын эрх зүйн баримт бичгийг боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх чиглэлээр ажилладаг ба конвенц, мэдэгдэл, тунхаглал, зөвлөмж батлан хэрэгжүүлдэг. Тухайлбал: ЮНЕСКО нь 1972 оны 10-р сарын 17-ны өдрөөс 11-р сарын 21-ний

өдрүүдэд Парис хотноо хуралдсан Ерөнхий бага хурлын 17 дугаар чуулганаараа Дэлхийн байгалийн болон соёлын өвийг хамгаалах тухай конвенцыг (Дэлхийн өвийн конвенц) баталжээ.



1-р зураг.
ЮНЕСКО-ийн
Дэлхийн өвийн
конвенцын лого

Дэлхийн өвийн конвенцод нэгдэн орсноор тухайн улс конвенцын Оролцогч улс болж, өөрийн орны нутаг дэвсгэрт байгаа соёлын болон байгалийн өвийг хадгалж хамгаалах, одоо болон ирээдүй хойч үедээ өвлүүлэн үлдээх үүрэг хариуцлагыг хүлээдэг. Өнөөгийн байдлаар (2019 он) Дэлхийн өвийн конвенцод 193 улс орон нэгдэн ороод байна.

Дэлхийн өвийг хамгаалах замаар дэлхий дахинд экосистемийг тогтвортой байлгах, биологийн болоод соёлын олон төрлийг хадгалж хамгаалах, хүн, байгаль, хөгжлийн тэнцвэрийг хангах явдал нь энэхүү конвенцын гол зорилго юм.

Уг конвенц нь өөрийн гэсэн жагсаалттай бөгөөд Оролцогч улс нь өөрийн орны төдийгүй дэлхий дахины гайхамшигт үнэт зүйл хэмээн тодорхойлж болох соёлын болон байгалийн дурсгалт газруудаа тус жагсаалтад бүртгүүлэх боломжтой юм. Дэлхийн өвийн жагсаалтад өвийг бүртгүүлэх нь юуны түрүүнд тухайн дурсгалт газруудыг алдаршуулах зорилготой бөгөөд бүртгүүлсэн цагаасаа тэрхүү өв нь олон улсын хамгаалалтад орж дэлхий даяараа хадгалж хамгаалах хамтын хариуцлагыг хүлээдэг.

Зүүн Африкийн Сэрэнгэти, Египетийн Пирамид, Австралийн Их шүрэн далан, Латин Америкийн Барок сүм зэрэг өөр өөр төрлийн өвөрмөц газрууд нь бидний дэлхийн өвийг бүрдүүлж байдаг. Дэлхийн өвийн ойлголтыг онцгой болгож буй зүйл нь бүх нийтийн хэрэглээ юм. Иймээс дэлхий өвийн газар нутгууд нь газар зүйн байршлаас үл хамааран дэлхийн бүх ард түмэнд хамаарна.

“Өв” хэмээх үг нь олон янз ойлголт, санааг агуулдаг бөгөөд өвийн тухай олон төрлийн тодорхойлолт дэлхий дахинд байдаг. Үүнээс Дэлхийн өвийн конвенцын өвийн тухай тодорхойлолт нь түгээмэл шинж чанарыг өөртөө агуулсан байдгаараа онцлог юм. Уг тодорхойлолтод өвийг “соёлын”, “байгалийн” болон “холимог” гэсэн үндсэн 3 төрөлд хуваадаг.

1.2.1 Дэлхийн соёлын өв

“Дэлхийн байгалийн болон соёлын өвийг хамгаалах тухай конвенц”-ын соёлын болон байгалийн өвийн тодорхойлолт дахь “соёлын өв” гэдэг ойлголтод:

- Хөшөө дурсгалууд: түүх, урлаг, шинжлэх ухааны хувьд дэлхий нийтийн хосгүй гайхамшигт үнэ цэн бүхий уран барилга, сүрлэг чимэглэлийн уран баримал, уран зургийн бүтээл, археологийн олдворууд, бичээс, агуй болон цогцолбор дурсгалууд;
- Уран барилгын цогцолбор: түүх, урлаг, шинжлэх ухааны хувьд дэлхий нийтийн хосгүй гайхамшигт үнэ цэн бүхий салангид буюу нэгдмэл барилга байгууламж, уран барилгуудын цогцолбор;
- Түүхийн дурсгалт газрууд: хүний болон хүн байгалийн хамтарсан бүтээлүүд мөн түүх, гоо зүй, угсаатны судлалын хувьд дэлхий нийтийн хосгүй гайхамшигт үнэ цэн бүхий археологи, түүхийн дурсгалт газрыг багтаасан бүс нутгийг оруулна...”¹ гэжээ.



2-р зураг

Кажурахогийн хөшөө дурсгалууд, Энэтхэг улс (Дэлхийн соёлын өв, 1986 он)

¹ 1972 оны Дэлхийн өвийн конвенцын үндсэн баримт бичгүүд, ЮНЕСКО-ийн Дэлхийн өв.7, place de Fontenoy. Парис хот 07 SP, Франц Улс (Албан хэрэгцээнд зориулав, 2016 оны 10 дугаар сарын хэвлэл). ЮНЕСКО-ийн хэвлэлийн газарт хэвлэв. — Х.З.

1.2.2 Дэлхийн байгалийн өв

Байгалийн өвийг Дэлхийн өвийн конвенцод дараах байдлаар хувааж байна. Үүнд:

1. Физик ба биологийн тогтоцууд: ой, мөнх цас мөс, арал, нуур агуй уул гэх мэт;
2. Ховор, ховордсон ургамал, амьтны төрөл зүйлийн амьдрах орчин: шүрэн арал, ширэнгэн ой, ус намгархаг газар гэх мэт;
3. Хуульчлан хамгаалсан байгалийн үзэсгэлэнт газар: тухайлбал, байгалийн цогцолборт газар, дархан цаазат газар гэх мэт.



3-р зураг.

Гунунг Тулу Үндэсний цэцэрлэгт хүрээлэн, Малайз улс
(Дэлхийн байгалийн өв, 2000 он)

1.2.3 Холимог өв

Соёлын болон байгалийн өвийн хоёулангийн шинж чанарыг агуулж буй газар нутгийг холимог өв хэмээн Дэлхийн өвийн конвенцод үздэг.

2019 оны байдлаар Дэлхийн өвийн жагсаалтад 167 орны 1121 өв бүртгэгдсэнээс 869 нь соёлын ангиллаар, 213 нь байгалийн ангиллаар, 39 нь байгалийн болон соёлын холимог ангиллаар бүртгэгдсэн байна.



4-р зураг.

Атос уул, Бүгд Найрамдах Грек улс (Дэлхийн холимог өв, 1988 он)

1.3 ДЭЛХИЙН ӨВИЙН УРЬДЧИЛСАН ЖАГСААЛТ БА МОНГОЛ УЛСААС ДЭЛХИЙН ӨВД БҮРТГЭГДСЭН ӨВИЙН ГАЗАР НУТГУУД

Монгол улс нь Дэлхийн байгалийн болон соёлын өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-ийн 1972 оны конвенцод 1990 онд нэгдэн орсон цагаас эхлэн конвенцын гишүүн улсын хувьд хүлээсэн үүрэг амлалтынхаа дагуу өөрийн улсын нутаг дэвсгэрт буй байгаль, соёлын өвүүдээ таних, олж илрүүлэх, судлах, хадгалж хамгаалах, сурталчлан алдаршуулах ажилд идэвхтэй оролцож байна. Анх удаа 1996 онд Дэлхийн өвийн жагсаалтад оруулж болох байгаль, соёлын өвийн Урьдчилсан жагсаалтыг боловсруулж Дэлхийн өвийн хороонд хүргүүлсэн төдийгүй, хамгийн сүүлд гэхэд 2014 онд уг жагсаалтаа шинэчлэн хүргүүлсэн. Өнөөдрийн байдлаар Монгол улсаас Дэлхийн өвийн урьдчилсан жагсаалтад дараах 12 өвийн газар нутаг багтаж байна. Үүнд:

Нэг. Байгалийн өв:

1. Монголын Их Говийн цөл нутаг (2014);
2. Монголын говь дахь Цэрдийн галавын үлэг гүрвэлийн өлгий нутаг (2014);
3. Дорнод Монголын тал нутаг (2014).

Хоёр. Соёлын өв:

1. Амарбаясгалант хийд, түүнийг хүрээлсэн соёлын дурсгалт газар (2014);
2. Балдан Бэрээвэн хийд, түүний тахилга шүтлэгт газар нутаг (2014);
3. Тахилгат Биндэр уул ба холбогдох соёлын өвийн газрууд (2014);
4. Хүннүгийн язгуурын оршуулгын цогцолбор дурсгалууд (2014);

5. Хөдөө арал дахь Монголын Эзэнт гүрний үеийн археологийн дурсгал, түүний орчмын соёлын дурсгалт газар (2014);
6. Буган хөшөө бүхий хүрлийн үеийн соёлын цогцолбор дурсгалууд (2014);
7. Монголын говь нутаг дахь хадны зургийн цогцолбор дурсгалууд (2014);
8. Монголын тахилгатай уулс (2015);

Гурав. Холимог өв:

1. Монгол Алтайн нурууны байгаль, соёлын дурсгалт газрууд зэрэг орно.

Конвенцын оролцогч тал нь ийнхүү өөрийн Урьдчилсан жагсаалтаас Дэлхийн өвд бүртгүүлэх өвийг сонгож номинаци бэлтгэн Дэлхийн өвийн хороонд нэр дэвшүүлдэг. Нэр дэвшүүлсэн өвийг Дэлхийн өвийн хорооны зөвлөх байгууллагууд болох Хөшөө дурсгал, түүх соёлын дурсгалт газрын олон улсын зөвлөл (ICOMOS), Олон улсын байгаль хамгаалах холбоо (IUCN), Соёлын өвийн хадгалалт, сэргээн засварлалт судалгааны олон улсын төв (ICCROM) зэрэг байгууллагууд дараах шалгуураар үнэлгээ хийж, Дэлхийн өвийн хороонд санал хүргүүлэх ба Дэлхийн өвийн хороо нь уг газрыг Дэлхийн өвийн жагсаалтад бүртгэх эцсийн шийдвэр гаргана.

ДЭЛХИЙ НИЙТИЙН ХОСГҮЙ ГАЙХАМШИГТ ҮНЭ ЦЭНИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРУУД

Дэлхийн өвийн жагсаалтад бүртгэхийн тулд тухайн газар нутгийн дэлхий нийтийн хосгүй гайхамшигт үнэ цэнийг нь илэрхийлэх дараах арван (10) шалгуурын аль нэг эсхүл түүнээс дээшийг хангасан байна.

Дэлхийн соёлын өвийн хувьд

- i) Хүн төрөлхтний уран сэтгэмж, суу билгийн сор болсон гайхамшигт бүтээлийн илэрхийлэл байх;
- ii) Дэлхийн соёлын орон зай эсхүл цаг хугацааны орчилд уран барилга байгууламж, технологийн хөгжил дэвшил, хөшөө дурсгал бүхий урлагийн бүтээл, хот төлөвлөлт, ландшафтын хийц бүхий хүн төрөлхтний үнэ цэнийг илэрхийлсэн онцгой солилцоог харуулсан байх;
- iii) Устаж үгүй болсон эсхүл одоо байгаа уламжлалт соёл буюу соёл иргэншлийн ховор нандин эсхүл дахин давтагдашгүй нотолгоо болох;
- iv) Хүн төрөлхтний түүхэнд онцгой ач холбогдол бүхий үеийг илтгэн харуулсан уран барилгын, технологийн хөгжил дэвшил бүхий цогц байгууламж эсхүл ландшафтын хосгүй гайхамшигт төрөл байх;
- v) Хүн байгальтайгаа харьцах харилцаа холбоо, нэн ялангуяа нөхөн сэргээгдэх боломжгүйгээр хувьсан өөрчлөгдөх үеийн соёлын илэрхийлэл бүхий уламжлалт суурин газар, ашиглаж буй газар нутаг эсхүл далай ашиглалт зэргийн хосгүй гайхамшигт жишээ байх;
- vi) Дэлхий нийтийн хосгүй гайхамшигт үнэ цэн бүхий урлаг, утга зохиол, сүсэг бишрэл, сэтгэхүйн цар хүрээний бүтээл, шууд эсхүл биет байдлаар холбогдох үйл явдал эсхүл одоо байгаа уламжлалтай холбоотой байх;

Дэлхийн байгалийн өвийн хувьд:

- vii) Байгалийн төгс үзэгдэл эсхүл байгалийн ер бусын гоо үзэсгэлэн, гоо зүйн ач холбогдол бүхий хэсгийг агуулсан байх;

ДЭЛХИЙ НИЙТИЙН ХОСГҮЙ ГАЙХАМШИГТ ҮНЭ ЦЭНИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРУУД

- viii) Амьд байгалийн он цагийн түүх, газар дэлхий хэлбэржин тогтох хөгжилд ихээхэн ач холбогдол бүхий геологийн үйл явц, тэрчлэн ач холбогдол бүхий геоморфик буюу физио-графикийн шинж чанарууд зэрэг газар дэлхийн түүхэн дэх гол гол үе шатуудыг төлөөлөн харуулсан хосгүй гайхамшигт жишээ байх;
- ix) Хуурай газар, цэвэр ус, эрэг орчмын ба далай тэнгисийн экосистем болон амьтан, ургамлын аймгийн хөгжин хувьсах экологийн болон биологийн онцгой чухал үйл явцыг төлөөлөн харуулсан хосгүй гайхамшигт жишээ байх;
- x) Биологийн олон янз байдал, ялангуяа шинжлэх ухааны болон байгаль хамгаалах үүднээс авч үзэхэд аюулд учраад байгаа дэлхий нийтийн хосгүй гайхамшигт үнэ цэнтэй ховордсон төрөл зүйлийг хадгалж хамгаалахад чухал бөгөөд ач холбогдолтой байгалийн оромж болсон тийм газар нутгийг багтаасан байх.


2019 оны байдлаар Монгол улсаас Дэлхийн өвийн жагсаалтад дараах 5 өвийн газар нутгийг бүртгүүлээд байна. Үүнд:

Дэлхийн соёлын өв:

1. Орхоны хөндийн соёлын дурсгалт газар (2004 он)
2. Монгол Алтайн хадны зургийн цогцолбор (2011 он)
3. Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг (2015 он)

Дэлхийн байгалийн өв:

1. Увс нуурын ай сав газар (2003 он)
2. Дагуурын ландшафт (2017 он)



5-р зураг.

Монгол улсаас Дэлхий өвийн жагсаалтад бүртгэгдсэн өвийн газар нутгуудын тархцын байршил



6-р зураг.

*Дэлхийн соёлын өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газар
(Монгол улс, 2004 он)*




7-р зураг.

*Дэлхийн соёлын өв-Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолбор
(Монгол улс, 2011 он)*




8-р зураг.

*Дэлхийн соёлын өв-Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг
(Монгол улс, 2015 он)*



9-р зураг.

*Дэлхийн байгалийн өв-Увс нуурын ай сав газар
(Монгол улс, ОХУ 2003 он)*



10-р зураг.

Дэлхийн байгалийн өв-Дагуурын ландшафт (Монгол улс, ОХУ, 2017 он)

1.4 ДЭЛХИЙН ӨВИЙН ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТЫН МЕНЕЖМЕНТ

Тухайн өвийн газар нутгийг Дэлхийн өвийн жагсаалтад нэр дэвшүүлсэн тохиолдолд Дэлхийн өвийн конвенцын Үйл ажиллагааны удирдамжийн дагуу тухайн өвийг хадгалж хамгаалах менежментийн төлөвлөгөөтэй байхыг шаарддаг². Энэ шаардлагыг хангаагүй тохиолдолд тухайн газрыг Дэлхийн өвд бүртгэж авахгүй юм. Энэхүү менежментийн төлөвлөгөө нь өвийн Дэлхий нийтийн хосгүй гайхамшигт үнэ цэн, бүрэн бүтэн байдал, унаган төрх байдлыг алдагдуулахгүйн тулд тухайн өвийг орон нутгийн, үндэсний, олон улсын хэмжээнд найдвартай, үр дүнтэй хадгалан хамгаалж, ирээдүй хойч үедээ өвлүүлэн дамжуулахад оршино.

Ийм менежментийн бодлого, үйл ажиллагааг конвенцын оролцогч улсын Засгийн газар, холбогдох яамны удирдлага чиг үүргийнхээ дагуу Дэлхийн өвийн газрын хамгаалалтын захиргаа байгуулж, орон нутгийн удирдлага, төрийн болон төрийн бус байгууллагууд, хувийн хэвшлийнхний дэмжлэг тусалцаа, нутгийн иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.

² Дэлхийн өвийн жагсаалтад бүртгэгдсэн бүх өвүүдийг хадгалж хамгаалах зорилгоор хууль эрх зүйн зохицуулалт бүхий бүтцийн болон уламжлалт хамгаалалт, менежментийн урт хугацааны зохистой тогтолцоог бүрдүүлсэн байх ёстой. Ийм хамгаалалтын зохих хил хязгаарыг тогтоосон байна. Үүний нэгэн адил оролцогч улс бүр нэр дэвшүүлсэн өвийг үндэсний, бүс нутгийн, орон нутгийн, уламжлалт түвшинд зохих хамгаалалтыг үзүүлэх хэрэгтэй. Ингэхдээ өвийг хамгаалах арга замыг тодорхой тайлбарлаж, нэр дэвшүүлсэн өвийн баримт бичигт тусгасан байна. (1972 оны Дэлхийн өвийн конвенцын Үндсэн баримт бичгүүд. Дэлхийн өвийн конвенцыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны удирдамж. II.Ф. Хадгалалт болон менежмент, 97)

Менежментийн бодлого, төлөвлөгөөг боловсруулан гаргахын өмнө тухайн өв, өвийн газарт холбогдох тал бүрийн судалгааг нарийвчлан хийх шаардлагатай. Өвийн оршин байгаа газар нутаг болон түүний орчны бүсийг нарийн тогтоон, байгаль орчны үнэлгээ хийж, хөгжлийн дарамт нөлөөллийг тодорхойлж, аялал жуулчлалын өнөөгийн байдал, цаашид хөгжүүлэх боломж, үүнтэй холбоотой дэд бүтцийг хөгжүүлэх талаар бодитой судалгаа хийх нь зүйтэй. Түүнчлэн орон нутаг, бүс нутгийн хөгжлийн хэтийн төлөвтэй уялдуулан менежментийн үйл ажиллагаа төлөвлөх шаардлагатай.

Хадгалалт хамгаалалтын менежментийн төлөвлөгөө нь тухайн өвийн үнэт зүйл, ач холбогдлыг тодорхойлох, хүрээлэн буй орчин, нийгмийн өөрчлөлтийн үед тухайн газрын ач холбогдлыг хамгаалахын тулд авч хэрэгжүүлэх ёстой хадгалалт хамгаалалтын бодлого, тухайн бодлогыг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө юм. Хадгалалт хамгаалалтын менежментийн төлөвлөгөөнд ач холбогдлыг хамгаалахын тулд ямар үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатайг тодорхойлж тусгана. Үүний дагуу дараах алхмуудыг хийх шаардлагатай. Үүнд:

1. Түүхэн судалгаа хийх

Хадгалалт хамгаалалтын менежментийн төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэхэд өвийн газрын тухай бүрэн ойлголттой байх нь маш чухал юм. Үүнд дараах сэдвүүдийг гаргасан байх шаардлагатай.

- Тухайн өвийн газрын байршил
- Эзэмшил ба менежментийн хариуцлага
- Холбогдох хууль эрх зүй, баримт бичиг
- Тухайн өвийн газрын түүхэн хөгжил
- Биет шинж чанар ба бүрдэл хэсгүүд

2. Хяналт шалгалт ба дүн шинжилгээ хийх

Нөхцөл байдлын үнэлгээ нь тухайн өвийн газрын биет хадгалан хамгаалалтын хэрэгцээг тодорхойлоход чухал үүрэгтэй. Иймд дараах зүйлсэд хяналт шалгалт, дүн шинжилгээ хийнэ. Үүнд:

- Засвар үйлчилгээ, сэргээн засварлалт эсхүл сэргээн босголтын шаардлага
- Шинэ барилга: нэмэлт өөрчлөлт, нөхөн сэргээлт
- Буулгах эсхүл зайлуулах санал
- Ашиглалтыг өөрчлөх санал
- Археологийн бүс дэх малтлагын менежмент
- Орох гарах гарцын шаардлагууд буюу яаралтай үеийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чөлөөтэй нэвтрэх орц гарц
- Гал түймрийн аюулгүй байдал, ахуй байдлын шалгуурууд
- Аюултай материалын менежмент
- Байгалийн гамшгийн эрсдэл: гал түймэр, үер, шуурга, ган гачиг

- Аюулгүй байдал: гал тавих, хулгай, вандализм /санаатайгаар хорлон сүйтгэх/
- Материалын болон хүний нөөцийн боломж
- Ач холбогдлыг илүү тодорхой болгох үүднээс тайлбар хийх боломж чадамж

3. Ач холбогдлыг үнэлэх

Менежментийн шийдвэр гаргахаас өмнө өвийн газар нутгийн ач холбогдлыг тодорхойлох нь суурь үйл ажиллагаа юм. Хадгалалт хамгаалалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулахад тухайн өвийн газар нутгийг бусад ижил төстэй өвийн газар нутагтай харьцуулах нь илүү нарийн дэлгэрэнгүй үнэлэлт, дүгнэлт өгөхөд чухал ач холбогдолтой бөгөөд ингэснээр өвийн бүрдэл хэсгүүдийг ойлгох боломжтой болно.

4. Хадгалан хамгаалах бодлого боловсруулах

Энэхүү бодлого нь тухайн өвийн газар нутгийн ач холбогдлыг ирээдүйд хадгалан хамгаалахын тулд юу хийх хэрэгтэйг тодорхойлно. Бодлогыг дэс дараалалтай, зорилго зорилттой, тэдгээрт хүрэх заавар зөвлөмжтэй байх шаардлагатай. Хадгалан хамгаалах бодлогод дараах зүйлсийг шаарддаг. Үүнд:

- Урсгал засвар, засвар үйлчилгээ, сэргээн засварлалт
- Өвийн газар нутгийн ашиглалтыг хэрхэн удирдах
- Шинэ хэрэглээ, одоо байгаа барилга байгууламжийн өөрчлөлт, шинэ барилга байгууламжийг хөгжүүлэх зэрэг өөрчлөлтийг зохицуулах
- Өвийн газар нутгийн ач холбогдлыг хэрхэн тайлбарлах
- Оролцогч талуудын оролцоо
- Хяналт шинжилгээний үр дүн
- Менежмент болон шийдвэр гаргалт

5. Үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах

Үйл ажиллагааны төлөвлөгөө нь хадгалан хамгаалах бодлогыг хэрэгжүүлэхэд хэзээ, хэрхэн хэрэгжүүлэх шаардлагатайг тодорхойлох ба санхүү, техникийн чадвар эсхүл хүний нөөц зэрэг эх үүсвэрүүдийг харгалзан үзэж мөрдлөг болгосон байна. Үйл ажиллагааны төлөвлөгөө нь дараах зүйлсийг агуулсан байна. Үүнд:

- Засвар үйлчилгээ, сэргээн засварлах тэргүүлэх чиглэл, хуваарь
- Тэргүүлэх чиглэлийн хадгалан хамгаалах ажлын төлөвлөгөө, хуваарь
- Менежментийн тодорхой асуудлуудыг шийдвэрлэх протоколууд зэрэг болно.

Дэлхийн өвийн газрын менежментийн бодлогын нэг чухал зангилаа асуудал бол түүний хадгалалт хамгаалалтад нутгийн иргэдийг өргөнөөр татан

оролцуулахаас гадна тэдний амьдрал ахуйд таатай нөлөөлж, дэлхийн өвийн газар нутагт амьдарч буйдаа бахархах, үр шим, өгөөжийг нь хүртэх явдал юм.

Менежментийн төлөвлөгөөнд судалгаа, хяналт шинжилгээ, сургалт, сурталчилгааны ажил, өвийг хадгалж хамгаалах, сэргээн засварлах арга хэмжээ, аялал жуулчлалын зохицуулалтын асуудлууд чухал байр суурь эзэлнэ.

Дэлхийн өвийн газар нутгийн хамгаалалтын захиргаа нь нэгэнт батлагдсан менежментийн төлөвлөгөөний дагуу хадгалалт хамгаалалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж, үйл ажиллагааны чиглэлийн дагуу Дэлхийн өвийн хороонд хугацаат тайланг хүргүүлнэ.

1.5 МОНГОЛ УЛСЫН НЭГДЭН ОРСОН ЮНЕСКО-ИЙН СОЁЛЫН КОНВЕНЦУУД

Монгол улс соёлын өвийг хамгаалж хадгалан, хойч үедээ өвлүүлэн уламжлуулах зорилгоор ЮНЕСКО-ийн таван конвенцод нэгдэн ороод байна. Үүнд:

1. Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлсийг хамгаалах тухай 1954 оны конвенц

Дэлхийн II дайны үед соёлын өв асар ихээр сүйрч, утсаны улмаас тус конвенцыг батлах үндэс бүрдсэн юм. Уг конвенц нь зэвсэгт мөргөлдөөн, дайн байлдааны үед соёлын өвийг хамгаалах тухай дэлхий дахинд гарсан анхны олон улсын гэрээ бөгөөд эзлэгдсэн нутаг дэвсгэрээс соёлын үнэт зүйлсийг гадагш зөөхөөс урьдчилан сэргийлэх, хэрэв гадагш зөөсөн бол уугуул нутагт нь буцаах асуудлыг зохицуулахын тулд баталжээ. Монгол улс тус конвенцод 1964 онд нэгдэн орсон.

1980 оны сүүлч 1990 оны эхээр зэвсэгт мөргөлдөөн болсон зарим улс оронд соёлын үнэт зүйлс олноор сүйрч, гэмтсэнээс болж Гаагийн конвенцод нэмэлт өөрчлөлт хийж, сайжруулах шаардлагатай гэж олон улс үзсэн тул 1991 оноос тус конвенцыг дахин нягталж эхэлсэн нь 1999 онд Гаагийн конвенцын хоёрдугаар протоколыг батлахад хүргэсэн.

Гаагийн конвенц болон түүний протоколыг баталснаас хойш арван зургаан жилийн дараа олон улсын хамтын нийгэмлэг, дэлхий дахиныг хамарч өргөжин тэлж буй соёлын эд зүйлсийн хууль бус худалдааг хумихын тулд соёлын өвийг хамгаалах үйл ажиллагааг өргөжүүлэхээр шийдэж “Соёлын үнэт зүйлсийг хууль бусаар хилээр гаргах, оруулах, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай ЮНЕСКО-ийн 1970 оны конвенцыг баталсан юм.

2. Соёлын үнэт зүйлсийг хууль бусаар хилээр гаргах, оруулах, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай 1970 оны конвенц

Энэхүү конвенцод нэгдэн орсон гишүүн орнууд өөрийн нутаг дэвсгэрт соёлын эд зүйлсийг хууль бусаар импортлох, экспортлох, дамжуулахыг хориглож, хамтран ажиллах үүрэг хүлээдэг. Эрчимтэй даяарчлал өрнөж, олон улсын худалдаа наймаа ихсэж, аялал жуулчлал урьд байгаагүйгээр хөгжиж буй өнөө үед соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, хууль бус худалдаа дэлхий нийтийн сэтгэл зовоосон асуудал болсоор байна. Ялангуяа манай улсад нийгмийн тогтолцооны шилжилтийн үеэс соёлын эд зүйлсийн хууль бус худалдаа ихсэж, монголын үнэт соёлын өвийг хил дамнуулан худалдаалах болсон бөгөөд өдгөө ч бүрэн зогсоож чадахгүй байна. Монгол улс тус конвенцод 1991 онд нэгдэн орсон.

3. Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай 1972 оны конвенц

Энэхүү конвенц нь дэлхий дахины хосгүй гайхамшигт үнэ цэн бүхий соёлын болон байгалийн дурсгалт газруудыг хадгалж хамгаалахад чиглэгддэг.

Соёлын болон байгалийн өв аяндаа эвдэрч гэмтэхээс гадна нийгэм эдийн засгийн амьдралын хувьсал өөрчлөлтийг дагалдан гарч буй хор хөнөөл, эвдрэл сүйрлийн улмаас устаж үгүй болох аюул улам ноцтой болж байгаатай уялдан олон улсын хамтын нийгэмлэг байгалийн болон соёлын өвийг хамгаалахад заавал оролцож хамтарсан үйл ажиллагаа явуулах нь илүү үр ашигтай гэж үзээд, орчин үеийн шинжлэх ухааны аргад үндэслэн дэлхий дахины ач холбогдолтой байгалийн болон соёлын өвийг нийтээр хамгаалах үр ашигтай систем тогтоох зорилгоор уг конвенцыг боловсруулж баталсан.

Энэхүү конвенц нь ЮНЕСКО-ийн конвенцууд дундаас хамгийн түгээмэл нь бөгөөд ялангуяа Дэлхийн өвийн жагсаалтаараа олонд танигдсан. Монгол улс тус конвенцод 1990 онд нэгдэн орсон.

4. Соёлын биет бус өвийг хамгаалах тухай 2003 оны конвенц

Уг конвенцыг 2003 онд баталсан нь даяарчлалын орчин үеийн үйл явцаас үүдэн соёлын биет бус өвд тулгараад буй аюул эрсдэлийг даван туулах, нэгдэн шийдвэрлэх алхам болсон юм. Конвенцын 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Соёлын биет бус өв гэж хамт олон, бүлэг хүмүүс, зарим тохиолдолд хувь хүмүүс соёлын өвийнхөө бүрэлдэхүүн хэсэг гэж хүлээн зөвшөөрсөн заншил, дүрслэх болон илэрхийлэх хэлбэр, мэдлэг болон дадал, эдгээртэй холбоо бүхий багаж зэмсэг, эд зүйл, урлагийн бүтээл, соёлын орон зайг хэлнэ. Үеэс үед уламжлагдах соёлын биет бус өвийг хамт олон, бүлэг хүмүүс нь тэдгээрийг хүрээлэн буй орчин, байгаль, түүхийн харилцан шүтэлцээнээс шалтгаалан байнга шинэчилдэг

бөгөөд тухайн өв нь тэдгээрт оршин тогтнох болон залгамж чанарын мэдрэмж төрүүлж, соёлын төрөл зүйл, хүний туурвилыг хүндэтгэхэд дэмжлэг үзүүлдэг. Энэхүү конвенцийн зорилгод олон улсын хүний эрхийн зөвхөн одоо мөрдөж буй баримт бичиг болон хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн хоорондын харилцан хүндэтгэл, мөн тогтвортой хөгжлийн шаардлагуудад нийцсэн соёлын биет бус өвийг авч үзнэ” гэжээ. Монгол улс тус конвенцод 2005 онд нэгдэн орсон.

5. Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай 2005 оны конвенц

Энэхүү конвенц нь соёлын илэрхийллүүдийг үйлдвэрлэхээс эхлээд, түгээх, дэлгэрүүлэх, үзэж сонирхох, хэрэглэх болон тэдгээрээс таашаал хүртэх зэрэг хүний бүтээлч үйлийн бүхий л хэлхээ, нөхцөлийг бүрдүүлж сайжруулах замаар соёлын олон төрлийг хөхиүлэн дэмжихэд чиглэгддэг.

Амьд байгальд биологийн олон төрөл зүйл зайлшгүй хэрэгтэй байдаг шиг хүн төрөлхтөнд соёлын олон төрөл хэрэгтэй бөгөөд соёлын олон төрөл бол хөгжлийн ундарга гэдгийг олон улс хүлээн зөвшөөрөөд байна.

Конвенц нь оролцогч улсууд хоорондоо тохирч эрх зүйн хувьд баталгаажуулсан гэрээ бөгөөд үндэсний болон олон улсын хэмжээнд нэгдсэн зорилгуудаа тодорхойлж, түүнд хүрэх арга барил, стандартыг тогтоодог бичиг баримт юм. Олон улсын эрх зүйн нэгдсэн баримт бичиг болохын хувьд тус конвенц нь соёлын илэрхийллийн олон талт байдлыг хамгаалж, хөгжүүлэхэд чиглэсэн соёлын бодлого, арга хэмжээг баталж, хэрэгжүүлэх болон үзэл бодол, уран бүтээлийн чөлөөт урсгалыг дэмжих талаар Засгийн газруудын эрх хэмжээг бататгасан.

Тус конвенц нь соёлын илэрхийллүүдийг бүтээлч байдлаар үйлдвэрлэхээс эхлээд, түгээх, дэлгэрүүлэх, үзэж сонирхох, хэрэглэх зэрэг хүний бүтээлч байдлын бүхий л нөхцөлийг бүрдүүлж сайжруулах замаар соёлын олон төрлийг хөхиүлэн дэмжихэд чиглэгддэг. Мөн хөгжим, дүрст бичлэг, гар урлал, уран зураг, үзүүлэн тоглолт зэрэг орчин үеийн, бие даасан соёлын илэрхийллүүдэд голлон анхаарч, соёлын бүтээлч үйлвэрлэлийг дэмжих, түүнчлэн соёлын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг зохицуулахыг зорьж байдаг. Монгол улс тус конвенцод 2007 онд нэгдэн орсон.

Дээр дурдсан конвенцуудад нэгдэн орсноос хойш Монгол улс, ЮНЕСКО-ийн соёлын салбар дахь хамтын ажиллагаа маш эрчимтэй хөгжиж байна. Эдгээр конвенцын хүрээнд олон улсын дэмжлэг тусламжийг авч ЮНЕСКО-ийн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх боломж нээгдсэн юм.

2.1 ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолбор” нь 2011 онд Бүгд Найрамдах Франц Улсын нийслэл Парис хотноо хуралдсан ЮНЕСКО-ийн Дэлхийн өвийн хорооны 35 дугаар ээлжит чуулганы шийдвэрээр Дэлхийн соёлын өвийн жагсаалтад бүртгэгдсэн бөгөөд манай улсаас Дэлхийн өвд соёлын ангиллаар бүртгэгдсэн хоёр дахь өвийн газар нутаг юм.

Энэхүү хадны зургийн цогцолбор нь нийт 11300 га талбайг эзлэн 3 хэсэг газарт орших бөгөөд Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутаг Арал толгой, Шивээт хайрхан, тус аймгийн Улаанхус сумын Цагаан салаа/Бага-Ойгор хэмээх газруудыг хамардаг.

Хадны зургийн эзлэх талбай, тоо хэмжээ, шинжлэх ухааны үнэ цэн, түүх, соёл, урлаг уран сайхны ач холбогдол, илэрхийллээрээ адил төрлийн дурсгалт газруудаас томд тооцогддог бөгөөд үүнийг ч дэлхий дахины эрдэмтэн, судлаачид нэгэн дуугаар хүлээн зөвшөөрдөг. Анх 1994 онд Монгол улсын Шинжлэх ухааны академийн Түүхийн хүрээлэн, АНУ-ын Орегони их сургууль, ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Археологи, этнографийн хүрээлэнгийн хамтарсан “Алтай” хэмээх төслийн хүрээнд судлаачид уг хадны зургуудыг илрүүлэн шинжлэх ухааны эргэлтэд оруулж судалж эхэлжээ.

Монгол, Америк, Оросын хамтарсан “Алтай” төслийн багийнхан 1994-2004 онд Баян-Өлгий аймгийн Хар ямаат, Цагаан салаа, Бага Ойгор, Хар ус, Цагаан ус, Шивээт хайрхан, Хар чулуу, Их Бага Хагийн гол, Хагийн нуур, Арал толгой зэрэг газруудаас шинэ чулуун зэвсгийн үеийн олон тооны хадны зургийг илрүүлэн судалж, олон арван ном илтгэл, өгүүллийг дэлхийн арав гаруй оронд англи, монгол, орос, франц зэрэг хэлээр нийтэлсэн байдаг.




11-р зураг.

Монгол, Орос, Америкийн "Алтай" төслийн судлаачид
(Д.Цэвээндорж, 2010 он)

Дэлхийн өвийн жагсаалтад нэр дэвшүүлсэн өвийг Дэлхий нийтийн хосгүй гайхамшигт үнэ цэнийг үнэлэх 10 шалгуураас нэг буюу түүнээс олныг хангаж байвал Дэлхий нийтийн хосгүй гайхамшигт үнэ цэнтэй өв гэж тооцож уг жагсаалтад бүртгэдэг.

Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолборын хувьд дээрх шалгууруудаас шалгуур 3 (iii) буюу "Өмнө нь байсан бөгөөд устаж үгүй болсон соёл иргэншлийг гэрчлэх балгас, соёл уламжлалын хосгүй өв" гэсэн шалгуурыг хангаж Дэлхийн өвд бүртгэгдсэн. Шалгуур 3 (iii) нь: "Монгол Алтайн хадны зургийн цогцолбор" нь Төв болон Хойд Азийн уулзварт, баруун хойд Алтайн уулсаар амьдарч байсан эртний хүмүүсийн аж амьдралын баримтжуулалтын гайхалтай жишээ юм. Эдгээр хадны зургуудад арслан заан, хирс, тэмээн хяруул зэргийн дүрсийг хөдөлгөөнгүй, хажуугаас нь дүрсэлсэн байдаг. Хойд Азийн бүс нутаг харьцангуй хүйтэн, хуурай, ой модгүй, харин бут, өвсөөр хучигдсан байх үед эдгээр амьтад энэ бүс нутагт амьдардаг байжээ. Хожуу Плейстоцений төгсгөлд (одоогоос ойролцоогоор 11,000 жилийн өмнө) хуурай хээр тал нь аажмаар мод ургамал ихтэй Голоцены эхэн үеийн (одоогоос ойролцоогоор 11,000 – 6,000 жилийн өмнө) байгаль орчноор солигджээ. Түүхийн энэ үеийг Монгол Алтайн хадны зургуудад хандгай, бух гөрөөс, янгир зэрэг амьтны дүрсээр уран тод тусгасан байдаг бөгөөд хүрэл зэвсгийн өмнөх үеийг дүрсэлсэн хадны зураг ийм олноор, төрөл бүрээрээ олдсон дурсгалт газар Хойд Азид маш цөөхөн байдаг" хэмээн тодорхойлжээ.



Энд чулуун зэвсгийн үеэс дундад зууны үе хүртэлх олон мянган жилийн буюу хүний хөгжлийн түүхийн олон үеийг нэг дор харуулж байдгаараа онцлогтой. Эдгээр хадны зургаас энэ бүс нутгийн эртний байгаль, хүрээлэн буй орчин, тухайн үед амьдарч байсан ан, амьтдын талаар мэдэж авахаас гадна Төв Азийн эртний хүмүүсийн аж ахуй, нийгмийн харилцаа, шүтлэг бишрэл зэрэг оюун санааны хөгжлийн олон талыг улируулан мэдэж болох эртний түүхийн чухал сурвалж болдгоороо шинжлэх ухааны өндөр ач холбогдолтой юм. Мөн тухайн хадны зургийг урласан өгүүлэмж, арга барил зэрэг нь эртний хүмүүсийн уран сайхны мэдрэмж, урлагийн хөгжлийг илтгэх чухал баримт болдог байна.

Тиймээс Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолбор нь манай улсын төдийгүй энэ бүс нутгийн ард түмний эртний түүх, урлагийн хөгжлийг харуулах чухал дурсгал болох бөгөөд дэлхийн алдарт хадны зургийн дурсгалт газрууд болох Альтамырын агуйн хадны зураг (Испани), Тамгалы дахь археологийн дурсгалууд ба хадны зургийн дурсгалт газар (Казахстан) зэрэг дурсгалуудтай эн зэрэгцэх юм.

Үүнтэй холбогдуулан Монгол улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Хадны зураг, бичээсийг хамгаалах, судлах ажлыг дэмжих тухай” 2017 оны 181 дүгээр зарлигтаа ...Хадны зураг, бичээсийг хадгалж хамгаалах, дэлхий дахинаа сурталчлан таниулах, аялал жуулчлалын шинэ хэлбэрийг хөгжүүлэх зорилгоор өргөн хүрээтэй, үр дүнтэй ажил зохион байгуулахыг бүх шатны засаг захиргааны байгууллагууд, төрийн болон төрийн бус байгууллага, шинжлэх ухаан, нийгэм соёлын зүтгэлтнүүд, аялал жуулчлалын байгууллага, ард иргэдэд уриалжээ.

2.2 ГАЗАР ЗҮЙ, БАЙГАЛЬ, ЦАГ УУРЫН ОНЦЛОГ

Алтайн нуруу нь БНХАУ, Казахстан, Монгол, ОХУ гэсэн дөрвөн улсын хилийг дамнан 1847 км урт, 1282 км өргөнтэй, 741 569 км² хэмжээтэй талбайг эзлэн оршдог. Алтайн нурууны зүүн хойд хэсэг нь манай улсын нутагт орох ба энэ хэсгийн уулсыг Монгол Алтайн нуруу хэмээн нэрлэдэг. Монгол Алтайн нуруу нь Монгол орны баруун хагаст, Монгол, Хятадын хил дагуу баруун хойноос зүүн урагш чиглэн 800 гаруй км урт сунаж тогтсон уулс юм.

Монгол Алтайн нуруу нь манай орны физик-газар зүйн ангиллаар Алтайн уулархаг их бүсэд хамаарах бөгөөд баруун өмнөд хэсгээр, зүүн урагшаа чиглэн 1800 орчим км үргэлжлэн тогтдог манай улсын хамгийн өндөр бөгөөд, урт үргэлжилдэг залуу атриат уул юм. Энэхүү бүсэд Монгол Алтай, Говь Алтайн нуруу нь гол суурь эзлэх бөгөөд Сийлхэмийн нуруу, Түргэн, Хархираа зэрэг уулсыг хамран 248900 гаруй ам дөрвөлжин километр талбайг эзэлдэг.

Тус бүсийн хил нь Үүрэг нуураас зүүн тийш байгаа Сагилын голын дунд биеэс Түргэн, Хархираа, Алтан Хөхий уулсын зүүн бэлийг барьж дараа нь Алтан

Хөхийн урд захаар үргэлжилсээр Ховд голыг Эрдэнэбүрэн сумын хавиар баруун урагш огтлон зүүн урагшаа эргэн Ховд хотын дэргэдүүр өнгөрч Манхан сум хүрнэ.

Монгол Алтайн нурууны ноён оргил нь 4374 метр өндөр Хүйтэн уул юм. Хүйтэн уулаас 3375 метр өндөр Гичгэний нуруу хүртэл 100 километр орчим урт цувралдан зэрэгцсэн уулсыг Алтайн нуруу гэнэ. Энэхүү нурууны 3500-4000 метр өндөрт нь мөсөн голууд оршдог. Хамгийн том нь Цагаан голын эхэнд 20 гаруй километр урт үргэлжлэх Потанины мөсөн гол юм. Алтайн нурууны таван их оргилыг нэрлэвэл, Хүйтэн оргил 4374 метр, Найрамдал оргил 4082 метр, Малчин оргил 4037 метр, Бүргэд уул 4068 метр, Өлгий оргил 4050 метр юм.

Уулсын ерөнхий төлөв нь баруун талдаа өргөн, зүүн талдаа нарийссан байдаг. Алтайн их бүсийн хамгийн өндөр нурууд баруун хойд захаар нь оршдог учраас баруун зүгийн чийглэг агаар тэдгээрийн баруун ба баруун урд хажууд хур тунадас авчран унагаж дотогшоо хуурайшин ордог байна. Тухайлбал, Монгол Алтайд нэг жилийн дотор унах тунадас 100-150 мм бол Говь-Алтайд 36-100 мм байна. Түүнчлэн дулааны нөөц ерөнхийдөө Хангай, Хэнтийн Их мужийнхаас илүү юм. Жилийн дундаж хэм хасах боловч Монгол Алтайн баруун хагаст 0-1,8 хэмээс хэтрэхгүй, харин Говь-Алтайд 4 хэм хүрдэг байна. Зуны хэм нь харьцангуй их учраас 10-аас дээш идэвхтэй температурын нийлбэр 2119-2605° байгаа нь Хангай, Хэнтийн уулсынхаас их юм. Дулааны нөөц илүү учир олон жилийн цэвдэг ул хөрс дэлгэр тархсан биш, зөвхөн өндөр уулсын оройн хэсэгт тархаж бага газрыг эзэлдэг байна.

Түүнчлэн 1996 онд байгуулагдсан Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газар нутгуудын хамгаалалтын (УТХГНХЗ) захиргаа нь Төв Азийн экологийн тэнцвэрт байдлыг хангахад чухал ач холбогдогдол бүхий Монгол Алтайн нурууны байгалийн бүс, бүслүүрийн онцлогийг төлөөлж чадах, өндөр уулын эмзэг экосистемийн бүрэлдэхүүн хэсэг Алтай Таванбогд, Сийлхэмийн нуруу, Цамбагарав уулын байгалийн цогцолборт газрууд, Ачит нуур, Дэвэлийн арлын нөөц газрын 1,0 сая орчим га талбай бүхий газар нутгийг хариуцан хамгаалах үүрэг хүлээж үйл ажиллагаагаа явуулдаг.

Үүнээс Алтай Таванбогдын байгалийн цогцолборт газар (БЦГ) нь 636161 га газрыг хамардаг бөгөөд хойт талаараа ОХУ, баруун талаараа Таван Богдоос баруун урагш Өвчүү уул хүртэл БНХАУ-тай хиллэдэг бөгөөд уртаашаа 186 км, өргөөшөө 42 км газар нутгийг хамардаг. Талбай нь бараг бүхэлдээ өргөгдсөн гадаргатай, далайн түвшнээс дээш 1800-4374м, хамгийн нам цэг болох Хурган нуур нь далайн түвшнээс 1800м өндөр юм. Эх газрын эрс тэс уур амьсгалтай, өндөр уулын болон уулын хээр, ойт хээрийн бүсийн хэв шинж зонхилсон өвөрмөц уур амьсгалтай, маш эмзэг экосистем юм. Тус байгалийн цогцолборт газар нь газрын гадаргын болон газар доорх усаар баялаг бөгөөд Хотон, Хурган,

Даян зэрэг мөстлөгийн гаралтай томоохон нууруудаас гадна 250 гаруй жижиг нуур, цөөрөм, гол горхи, алтайн сугас, монгол хадран зэрэг баруун Монголын эндемик загас элбэг байдаг. Түүнчлэн, өндөр уулын мөнх цас, мөсөн гол, ян сарьдаг, уулын нуга, хээрийн ландшафт, экосистемийн онцлогийг төлөөлсөн үзэсгэлэнт байгальтай бөгөөд алтайн аргаль хонь, янгир ямаа, халиун буга, алтайн хойлог, тас, ёл зэрэг жигүүртний гол байршил болдгоороо зайлшгүй хамгаалах шаардлагатай газар нутаг юм.

Алтай Таванбогдын БЦГ-ын Дөнхөрөгийн уулын орчимд Цагаан Усны халуун рашаан /38-45 хэм/ нь далайн түвшнээс дээш 2600-2800м өндөрт оршино. Рашааны физик-химийн шинж чанар нь нилээд өвөрмөц, сулавтар хүхэрт устөрөгчийн үнэртэй, орчин нь шүлтлэг, ундарга нь тунгалаг. Рашаан бага зэрэг цацраг идэвхт, радионы агуулгатай учраас унданд хэрэглэхийг зөвшөөрдөггүй байна.

Сийлхэмийн нурууны байгалийн цогцолборт газар (БЦГ) нь Баян-Өлгий аймгийн Улаанхус, Ногооннуур сумын нутагт улсын хил дээр, өргөргийн дагуу сунаж 142788 га газрыг хамран оршдог. Энэхүү БЦГ нь А, Б гэсэн хоёр хэсэгтэй. Учир нь уг цогцолборт газрын дундуур ОХУ руу гардаг Цагааннуурын хилийн боомт ажиллаж байгаа учраас дундуур нь коридор гаргасан байна. Уг газар нутагт дэлхийд болон Монголд ховордсон цоохор ирвэс, алтайн аргаль хонь, янгир ямаа, саарал чоно, мануул мий, ёл, тас, цармын бүргэд, алтайн хойлог, цэвдгийн цагаан ятуу, цагаан шонхор зэрэг ан амьтнаар элбэг тул улсын тусгай хамгаалалтад авчээ. Сийлхэмийн нурууны БЦГ-ын "А" хэсэгт оршдог Цагаан салаагийн хадны зураг бүхий хэсэг нь Дэлхийн өв-Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолборын газар нутагт хамаардаг.

2.3 ХАМГААЛЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол улсын Засгийн газрын 2018 оны 299 дүгээр тогтоолоор Дэлхийн өвд бүртгэгдсэн газар нутгийг хадгалж хамгаалах, судлах, сурталчлах үүрэг бүхий Монгол Алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргааг байгуулахаар баталсан бөгөөд хамгаалалтын захиргааны бүтэц, орон тоог 12 хүнтэйгээр баталж, үйл ажиллагааг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлүүлэхээр болсон байна. Хамгаалалтын захиргааны үйл ажиллагааг эхлүүлэх хүртэлх хугацаанд түүний чиг үүргийг Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газар нутгуудын хамгаалалтын захиргаанд (УТХГНХЗ) түр хариуцуулсан байна.

Монгол Алтайн нурууны УТХГНХЗ-ны үндсэн зорилго нь улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийн нэн ховор, ховордсон амьтан, ургамлын аймаг, Баруун Монголын гадагш урсгалгүй ай савын цэнгэг усны нөөц, мөнх

цас, мөсөн голууд, эртний түүх, соёлын дурсгалт зүйлсийг шинжлэн судлах, танин мэдэх, хадгалж, хамгаалах, нөхөн сэргээх, урт хугацаанд тогтвортой ашиглах боломжийг бүрдүүлэхэд оршиж байна. Тус хамгаалалтын захиргаа нь байгаль хамгаалалд орон нутгийн төр, захиргааны болон иргэний нийгмийн байгууллагууд, өргөн олон түмний оролцоог нэмэгдүүлж хамтын менежментийг хэрэгжүүлэхэд анхаарч, гадаад, дотоодын жуулчид, нутгийн иргэдийг холбогдох мэдээллээр хангаж ажилласаар байна. УТХГНХЗ-ны хамгаалалттай газруудын байгаль орчин нь харьцангуй унаган төрхөөрөө хадгалагдсан байдаг ба ус, хөрс, агаарын бохирдолт үүсгэдэг уул уурхай хөгжөөгүй. Гагцхүү улирлын чанартай хүн ам ихээхэн нягтарч, малын тоо толгой бэлчээрийн даац хэтэрч, бэлчээр талхлагдан экосистемд бүхэлдээ муугаар нөлөөлж цаашид цөлжих нөхцөл бүрдэх сөрөг талтай байгааг дурдах хэрэгтэй. Монгол Алтайн нурууны уур амьсгал, улирлын өөрчлөлт, дулаарлын нөлөө, цаг агаарын элдэв үзэгдлүүдийн улмаас биологийн бүлгэмдлүүд энэхүү өөрчлөлтөд дасан зохицох эсвэл нүүн шилжиж амжилгүй амьдрах орчин алдагдаж болзошгүй юм. Түүнчлэн, дэлхийн өвийн газар нутгийг цаашид хадгалан хамгаалахад дараах арга хэмжээг авах шаардлагатай байна. Үүнд:

1. Дэлхийн өв болон түүх соёлын дурсгалуудыг аялагч, жуулчид үзэж сонирхох нөхцөлийг бүрдүүлэх, хамгаалалтыг сайжруулах, зориулалтын зам, зогсоол гаргаж аяллын маршруттай болгох, бусад мэдээлэл, үйлчилгээгээр хангах боломжийг бүрдүүлэх, зөвшөөрөлгүй зам, гарцыг хаах,
2. Дэлхийн өвийн газар нутгийн иргэдэд Дэлхийн өвийн ач холбогдлыг сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулах, хууль сурталчилж эрх үүргийг таниулах,
3. Өвийн газар нутгийн ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдэд чиглэсэн сургалт сурталчилгааг зохион байгуулах,
4. Дэлхий өвд бүртгэлтэй газар нутгийг хариуцан хамгаалж буй Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаад дэлхийн өвийн хадгалалт хамгаалалт, сурталчлан танилцах арга хэмжээг зохион байгуулах, тухайн жилийн төлөвлөгөөнд тусгаж биелэлтийг ханган ажиллах,
5. Их, дээд сургуулиудад соёл судлаач, сэргээн засварлагч, археологич бэлтгэхэд урамшуулал, дэмжлэг үзүүлэх, мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадвар дээшлүүлэх сургалт, харилцан туршлага солилцох үйл ажиллагааг гадны улс орнуудтай хамтран тогтмол зохион байгуулах,
6. Булш дурсгалыг ухаж хөндсөн тохиолдолд цаг алдалгүй шалгаж, холбогдох мэдээллийг хууль хяналтын болон хариуцсан төр, захиргааны байгууллагуудад мэдэгдэж холбогдох арга хэмжээг тухай бүрт авах шаардлагатай юм.

2.4 ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ, БАЙРШИЛ

2.4.1 Баян-Өлгий аймаг

1940 оны 6 дугаар сард хуралдсан Улсын VIII Их Хурлаас *“Казах ба Урианхайн ард түмний санал хүсэлтийг үндэслэн Ховд аймгаас салгаж, Казах, Урианхай нарын үндэсний аймаг байгуулахыг Улсын бага хуралд даалгасугай”* хэмээх тогтоол батлагджээ. Ийнхүү Баян-Өлгий аймаг 10 сум, 71 баг, 7063 өрх, 32301 хүн ам, 847.9 мянган малтай бие даасан аймаг болон зохион байгуулагдсан байна. Аймаг байгуулагдах үеийн хүн амын 91.0 хувь нь Казах, 5.6 хувь нь Урианхай, 2.7 хувь нь Тува, 0.7 хувь нь бусад угсаатан байжээ. Улсын бага хурлын шийдвэрээр 1942 онд Ойгор, Буянт, 1946 онд Ховд, 1949 онд Булган, Ногооннуур сум шинээр байгуулагдсан байна.


Тус аймаг нь Монгол Алтайн нурууны өндөрлөг уулархаг нутагт оршдог 45.7 мянган км² нутагтай, 13 сум, 90 багтай. Баян-Өлгий аймгийн нийт сум өндөр уулын бүсэд хамрагдана. Аймгийн нийт нутгийн 78.2 хувийг бэлчээр, 0.3 хувь хадлангийн талбай, 0.5 хувийг ойн талбай эзэлдэг. Аймгийн нийт нутгийн 95.3 хувь нь далайн түвшнээс 1300-1400 метрийн өндөрт өргөгдсөн, баруун талаараа Алтайн нурууны хяр дагаж БНХАУ-ын Шинжаан-Уйгарын Өөртөө засах оронтой 450 км, хойт талаараа Сийлхэмийн нуруу дагаж ОХУ-ын Алтайн Бүгд Найрамдах Улстай 225 км, зүүн талаараа Увс аймагтай 165 км, зүүн барууд талаараа Ховд аймагтай 450 км нутгаар хиллэдэг.

2017 оны байдлаар Баян-Өлгий аймаг нийт 101.6 мянган хүн амтай, засаг захиргааны 14 нэгжтэй (13 сум, 1 тосгон), аймгийн төв Өлгий хотод 32 мянга гаруй иргэн оршин суудаг бөгөөд нийслэл Улаанбаатараас 1760 км зайд оршдог, 2226.1 сая мал тоолуулсан байна.

2.4.2 Улаанхус сум

Улаанхус сум 1938 онд Ховд аймгийн харьяанд Цагаангол сум болон казахын Шерүүч хошууны Бахад сумын зарим багийг багтаан байгуулагдаж, 1940 онд Баян-Өлгий аймагт шилжиж ирсэн байна. 1942 онд Цагаангол болон Улаанхус сумын нутгаас тасалж Ойгур хэмээх сумыг байгуулсан бөгөөд 1963 онд татан буулгаж Улаанхус сумтай нэгтгэжээ.

Улаанхус сум нь аймгийн төвөөс 45 км-т Билүү хэмээх газарт Согог голын зүүн Улаанхус сум эрэг, Ховд голд цутгах цутгалын зүүн талд оршино. 2010 оны улсын тооллогоор 7320 хүн ам бүртгэгдсэн бөгөөд энэ нь аймгийн нийт хүн амын 8.6%-ийг эзэлж байна. Тус сум нь Ногооннуур, Өлгий, Сагсай, Цэнгэл сум, ОХУ-ын Уулын Алтайн БНУ-тай тус тус хиллэдэг.



13-р зураг.

Цагаан салаа / Бага ойгорын дурсгалт газрын хадны зургийн байршил, хамгаалалтын бүс

Цагаан Салаа / Бага Ойгор: Бага Ойгорын гол, түүний дээд хэсгийн цутгал Цагаан салаа голын хөндийг хамарсан 20 орчим км урт үргэлжлэх хадны зургийн дурсгалт газар нь Баян-Өлгий аймгийн төвөөс баруун хойш 140 км орчим зайд, Улаанхус сумын нутагт орших бөгөөд хамгаалалтын үндсэн талбайг 2100 га, хамгаалалтын бүс 3600 га, нийт 5700 га-гаар хамгаалалтын бүсийг тогтоосон байна.

Тус хадны зургийн цогцолбор дурсгал нь Бага Ойгор голын баруун, зүүн эргийн дагуу 20-иод км, мөн Цагаан салаа, Бага Ойгорын голын зүүн эрэгтэй нийлсэн энгэр сугаар 400 орчим метр дээш сунан үргэлжилсэн байдалтай оршдог.

Нийт хадны зургийг Цагаан салаа 1-5, Бага ойгор 1-5 гэсэн 10 хэсэг болгон хувааж бүртгэн тэмдэглэсэн байна. Судлаачид хадны зургуудыг 2000 орчим ургаа хад болон бул чулууны гадаргуу дээр сийлсэн болохыг тогтоожээ. Нэг бул чулуун дээр дунджаар 1-180 орчим зураг, дүрс сийлсэн байгаа бөгөөд тус цогцолбор газарт ойролцоогоор 75 000 - 100 000 хүртэл зураг, дүрс байна хэмээн тооцоолжээ.



14-р зураг.

Цагаан салаа/Бага ойгорын хадны зураг

Цагаан салаа, Бага Ойгорын хаднаа чулуун зэвсгийн үе (одоогоос 40-12 000 жил), хүрэл, төмөр зэвсгийн түрүү үе (одоогоос 4-2 000 жил), Түрэг, Уйгурын үе (одоогоос 1400-1200 жил)-д холбогдох хадны зургууд байгаа боловч ихэнх зураг нь хүрэл, төмөр зэвсгийн түрүү үед холбогддог байна.

Хүрэл зэвсгийн үеийн хадны зургуудад мал гаршуулж буй, олноороо хоморголон ан ав хийж буй, үхэрт нуруу ачаа ачиж буй, сүйх тэрэгтэй явж буй, эр эмийн ёс үйлдэж буй зэрэг янз бүрийн өгүүлэмжтэй зургууд маш олноороо нэг талбайд байдгаараа онцлогтой. Цагаан салаа, Бага Ойгорын хадны зурагт үхрийн дүрслэл олон тоотой бөгөөд онцгой чухал байр суурийг эзэлнэ. Үхрийн толгой, эвэр, их бие, сүүл зэрэгт нар дүрсэлсэн нь тэнгэрийн амьтан болохыг бэлгэдсэн бололтой. Мөн үхэр агнаж буй анчин, үхэр хөтөлж яваа, үхэр унасан, үхэрт ачаа ачсан зэрэг баялаг сэдэв, зохиомжоор дүрсэлжээ. Үхрийн нуруунд янз бүрийн хэлбэртэй ачаа, ачаан дотор суусан хүүхэд, олон урт залмыг ачаанаас дээш гозойлгон дүрсэлсэн байдаг нь аж ахуй, зан заншил, оюуны соёлын олон талыг харуулсан эртний хүмүүсийн түүх, соёлын чухал баримт болох юм.


2.4.3 Цэнгэл сум

Цэнгэл хайрхан сум нь 1936 онд Ховд аймгийн харьяанд, Цагаангол сум нь 1938 онд мөн Ховд аймгийн харьяанд казахын Шерүүч хошууны хагас, Курман Санрау сумаар тасалж тус тус байгуулагдсан бөгөөд 1940 онд Баян-Өлгий аймгийн харьяанд шилжин ирсэн 10 сумын хоёр нь юм. 1956 онд энэ хоёр сумыг нэгтгэж одоогийн Цэнгэл сумыг үүсгэн байгуулжээ.

Цэнгэл сум нь аймгийн төвөөс баруун хойш 79 километрт Ховд голын баруун хөвөөнд Хөшөөт хэмээх газар оршино. 2010 оны улсын тооллогоор 7894 хүн ам бүртгэгдсэн бөгөөд энэ нь аймгийн нийт хүн амын 9.3%-ийг эзэлж байна. Сумын нийт хүн амын 18,6%-ийг тувачууд эзэлдэг. Тус сум хойд, зүүн хойд, талаараа Улаанхус сумтай, зүүн урд талаараа Сагсай сумтай хиллэхээс гадна

баруун урд болон баруун талаараа БНХАУ-ын Шинжан-Уйгурын ӨЗО, баруун хойд талаараа ОХУ-ын Уулын Алтайн БНУ-тай хиллэдэг.


Шивээт хайрхан: Цэнгэл сумын нутаг Шивээт Хайрхан уул, түүний хоёр талаас урсах Цагаан салаа, Хар салаа хоёр голын савд орших Хөх чулуу, Хар чулуу зэрэг газарт орших хадны зургийн дурсгалт газар нь нийт 240 гаруй хаданд зурсан зохиомж зурагнаас бүрдэнэ. Тус дурсгалт газар нь Цэнгэл сумын төв Хөшөөт суурингаас 80 орчим км зайд орших бөгөөд хамгаалалтын үндсэн талбайг 9,000 га, хамгаалалтын бүс 6,300 га, нийт 15,300 га талбайг хамарна.



Шивээт хайрханы хадны зураг нь Монгол Алтайд аж төрөн нутаглаж байсан овог, аймгуудын хүрлийн түрүү үеэс Түрэгийн үе хүртэлх түүхийн нэн урт хугацаанд хамаарах боловч зургуудын ихэнх хувийг хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үед үйлдсэн бөгөөд голчлон “амьтны загварт” аргаар дүрсэлсэн буга, шувуу, марал буга болон тэмээ унасан хүмүүс, дайчдын тулаан, зэр зэвсэг, хүүхдээ тэвэрсэн эхийн дүр, эр эмийн ажил хийж буй хүмүүсийн дүрслэл хийгээд эртний туг, далбаа, адуу, үхэрт хөллөсөн тэрэг, гэр оромж гэмээр зүйлсийг дүрслэн зуржээ.

Монгол Алтайн нуруунаас морин тэрэг дүрсэлсэн 100 орчим зураг олдоод байгаа бөгөөд Шивээт хайрханы нэгэн хаднаа том, жижиг хэмжээтэй янз бүрийн хийцтэй 60 орчим эртний тэрэгний зураг олдсон нь эртний морин тэрэг судлалд

чухал хэрэглэгдэхүүн бөгөөд ийм сонирхолтой олон тэрэгний зураг нэг дороос олдож байгаагүй аж.




16-р зураг.

Шивээт хайрханы хадны зураг


Түүнчлэн, хос морь хөтөлсөн хоёр том дугуйтай тэргэн дээр зогсож яваа хүнийг гээг үс, зэр зэвсэг, хувцас зэргийг маш нарийнаар дүрсэлж үзүүлсэн нь судалгааны чухал хэрэглэгдэхүүн болохыг судлаачид тэмдэглэсэн байдаг. Бас нэгэн сонирхолтой дүрслэл нь олон тооны ачаатай үхэр болон хүн, амьтдын дүрслэл бөгөөд эдгээрийн дотор нум сумаар харвалдан тулалдаж буй хүмүүс, үхрийн сүүлийг том дугуй дүрсээр чимж үзүүлснээрээ онцлог.

Арал толгой: Алтай таван богдын өвөр биеэс эх аван урсах Хар салаа, Цагаан салаа голын уулзварт орших Хурган нуур, Хотон нуур хэмээх хоёр залгаа нуурын хойд талд орших жижиг толгойг Арал толгой гэнэ. Тус дурсгалт газар нь Цэнгэл сумын төв Хөшөөт суурингаас 150 орчим км зайд, хилийн заставын орчим байрлана. Арал толгойн дурсгалт газрын хамгаалалтын үндсэн талбайг 200 га, хамгаалалтын бүсийг 800 га, нийт 1000 га-аар тогтоосон бөгөөд хамгийн бага талбайг хамарна.

Арал толгойн өвөр болон оройн хэвтээ хаднаа олон тооны амьтдын зургийг хонхойлон цохиж сийлсэн байдаг. Эдгээрээс судлаачид 170 орчим хадны зургийг баримтжуулан судалсан ба ихэнхийг нь мезолит, неолит, хүрэл зэвсгийн үеийн анчдын бүтээсэн дурсгал хэмээн үзсэн байна. Үүнд, махир эвэртэй хоёр үхрийн гадаад тэгийг хөвөөлөн цохиж, эхлээд дутуу орхисон зураг нь Монголын хуучин чулуун зэвсгийн үед холбогдох Ховд аймгийн Манхан сумын нутаг Ишгэн толгойн хадны зурагтай, мөн нэг үхрийн зургийн дээр хожим янгирын зургийг давхардуулан сийлсэн болон шувууны дүрсийг хамт цоолборлосон байдаг нь Ховд аймгийн Манхан сумын нутаг Хойд Цэнхэрийн агуйн зосон зурагт дүрсэлсэн тэмээн хяруулын зурагтай ижил төсөөтэй зэрэг шинжээрээ эртнийх болохыг нотолж байна. Хадны зургийн хамгийн эртнийх нь адуунаас томоор дүрсэлсэн тэмээн хяруул, адууны дүрс бүхий зохиомжууд, буга, үхэр зэргийн зураг бөгөөд зарим зургийг зориуд гүйцээлгүй дутуу орхисон байдаг нь эртний шинж юм.



17-р зураг.
Арал толгойн байршил, хамгаалалтын бүс




18-р зураг.
Арал толгойн хадны зураг

Арал толгойн хадны зурагт адуу, тэмээ, үхэр унасан, ачсан эсвэл мал хөтөлсөн зураг байхгүй бөгөөд тэмээн хяруул, нум сум, богино жадны хэлбэр төрх зэрэг байгаа боловч тооны хувьд харьцангуй цөөн эртний хэв шинж дүрслэлд тулгуурлан эртний мезолитын үед урлажээ хэмээн баттай үзэхэд хүргэж байна.

Түүнчлэн, хадны зургийн ихэнх хэсгийг хүрэл зэвсгийн үед бодит байдлаар дүрсэлсэн бөгөөд 272 зургаас зөвхөн 3 зураг (хоёр нь мал аж ахуйтай холбоотой) болон богино жад, алхан зээтүү, эртний энгийн богино нум сумаар ан хийж буй анчдын зураг зэрэг нь эртний шинжийг агуулдаг байна.

Арал толгойн хадны зургийн дүр, зохиомж бүрийг нарийвчлан судалсны үр дүнд тэдгээр зургийн ихэнх хэсэг 90 хувь орчим нь зэрлэг ан амьтад ба ан агнууртай холбоотой байхад, зөвхөн 7 хувь орчим нь мал ба мал аж ахуйтай холбоотой байна. Иймд Арал толгойн хадны зураг үндсэндээ эртний анчдын бүтээсэн дурсгал болж байгаагаараа онцлог юм.



3

ДЭЛХИЙН ӨВИЙН ГАЗАР НУТАГ ДАХЬ СОЁЛЫН ӨВ

3.1 УГСААТНЫ ТОВЧ ТҮҮХ, СОЁЛЫН БИЕТ БУС ӨВ

2010 оны тооллогоор Баян-Өлгий аймгийн хүн амын 90.1 хувь Казах, 6.2 хувь Урианхай, 1.8 хувь Тува, 1.0 хувь Дөрвөд, 0.9 хувийг бусад угсаатнууд эзэлж байна.

Казах: Монгол улсын хүн амын 5 гаруй хувийг эзэлдэг түрэг хэлт, ислам шүтлэгтэй казахууд эрт дээр үеэс Дундад Азийн төв хэсэг, өнөөгийн Казахстан улсын нутаг дэвсгэрт оршин амьдарч байсан нүүдэлчин ард түмэн бөгөөд нийт казах угсаатны нэг хэсэг эртний Керей овог аймгийнхан юм. Монгол улсад үндэстний цөөнхийн төлөөлөл болдог монголын казахууд түүхийн урт хугацаа, нийгэм улс төрийн амаргүй нөхцөлд яс үндэс, хэл соёл, шашин шүтлэг, ёс заншлаа цэвэр ариунаар хадгалж хамгаалж яваа цөөхөн ард түмний нэг билээ. Анх XIX зууны сүүлчээр цөөн тооны өрх зуд турхнаас болж Алтайн нурууны зүүн талд ирж суурьшжээ. Манжийн ноёрхол мөхсөний дараа 1912 онд казахын нөлөө бүхий хүмүүс 400 гаруй өрхийн нэрийн өмнөөс Монгол улсад дагаар орох хүсэлтийг Богд хаанд илгээж байжээ. Богдын Засгийн газар уг хүсэлтийг 1912 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр ёсоор болгож, казахын 11 ноёнд хэргэм зэрэг олгосон ба улмаар 1917 оны 3 дугаар сарын 23-ны өдөр казахууд Монгол улсын жинхэнэ харьяат иргэд болцгоожээ. 1940 онд Ховд аймгийн баруун хэсгийг салган казах урианхайн Баян-өлгий аймгийг байгуулж, төвийг нь Ховд голын хөвөөнд Өлгий гэдэг газар суурьшуулсан байна.

Казахууд гэр бүлийн ёс заншил, хурим найрын зан үйл, үндэсний хувцас, хэрэглэл, уламжлалт хоол хүнс, гар урлал, хэл, бичиг, урлаг соёлын өв, сүсэг бишрэл, шашин шүтлэгийн өөрсдийн өвөрмөц онцлог, нийтлэг зан үйлтэй.

Монголын Казахуудын дунд “Харбек”, “Хамбар”, “Төре хаан”, “Шора баатар” зэрэг эх хэл, аман уламжлалын илэрхийлэл болсон тууль, ардын язгуур урлагийн төрөл багтах мэтгэлцээний харилцаа дуу болох “Айтыс”, үндэстний хөгжмийн

зэмсэг болох доомбор, кобыз, сыбызгы зэргээр хөгжимдөн аялгуулах ардын авьяастан олон байдаг. Казахуудын хурим найрын үед заавал хийх биелгээний нэг нь “кара жорга” буюу “жороо хар” нэртэй олуулаа хийдэг биелгээ юм.

Казах бүсгүйчүүдийн ухаан, гарын ур шингэсэн үндэсний уран хээ угалзаар чимэглэсэн гар урлалын нэгэн төрөл болох нэхмэл хатгамал буюу “терме”, эсгий ширмэл урлал болох “сырмак”, дэрсийг өнгийн утсаар ороон сүлжиж хийдэг гэрийн давхар хана болох “шышми” урлал нь монголын бусад угсаатан ястныхаас өвөрмөц содон байдаг.

Казахын ард түмний хамгийн өргөн тэмдэглэгдэг үндэсний баяр нь исламын шашинтай улс үндэстнүүд жил бүрийн 3 дугаар сарын 22-ны өдөр тохиодог хүйтэн өвлийг өнтэй давж, урин хаврыг угтан авч буйн бэлгэдэл нарны баяр-хаврын баяр юм.

Монгол улсын Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор “Наурызын баяр”-ыг тэмдэглэлт өдрийн жагсаалтад албан ёсоор оруулжээ.

Монголчууд эртнээс шонхор шувуугаар ан хийж, цагаан шонхор шувууг туг сүлдэндээ дээдэлж ирсэн түүхтэй. Шувуучлахуйн нэг гол хэлбэр болсон бүргэдээр ан хийх зан үйлийн амьд уламжлал казах үндэстний дунд өнөөг хүртэл язгуур хэв шинжээрээ уламжлагдаж, ахуйн хэрэгцээ төдийгүй уламжлалт зан үйл, баяр наадам, уралдаан тэмцээний агуулгыг шингээн иржээ.



19-р зураг.

Шувуучлахуй буюу бүргэдээр ан хийх зан үйл өвийн батламж

Монгол улс нь ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийн Хүн төрөлхтний төлөөллийн жагсаалтад 2010 онд Шувуучлахуй буюу бүргэдээр ан хийх зан үйлийг Ази, Африк, Европын 11 улс болох Арабын Нэгдсэн Эмират, Бельги, Чех, Франц, Бүгд Найрамдах Солонгос Улс, Марокко, Катар, Саудын Араб, Испани, Сири улстай хамтран бүртгүүлсэн билээ.

Алтайн Урианхай: Эртний Монголын дарлиган аймаг. Х зууны үеийн хятад сурвалжид гарах “улянха” овгийг судлаачид урианхай гэж үздэг.

Урианхай нар IV-IX зууны үед Далай нуурын зүүн талаар нутаглаж байгаад Х зууны үед баруун тийш нүүдэллэн Хэнтий уул, Байгаль нуурын зүүн урдуур амьдрах болжээ. Улмаар Их Монгол улсын бүрэлдэхүүнд багтаж зургаан мянганд хуваагдсанаар зарим нь Хянганы нуруу, Цагаан хэрмийн араар нутаглах болж, XVI зууны үед харчин, түмэд нартай холилдон Өвөр Монголын зүүн хэсэгт суужээ. Бурхан халдунд үлдсэн урианхай нар их хаадын оршуулгын газрыг сахин хамгаалж суусан гэдэг. Тэд XV зуунаас зүүн Монголын нэгэн түмэн болж яваад Батмөнх даян хааныг эсэргүүцэн тэмцсэнээс бут цохиулан бутран сарнижээ. XVI зууны сүүлчээр баруун тийш нүүдэллэж Алтайд хүрч Халхын Засагт хан аймгийн харьяанд орсон ба эдүгээ урианхайчууд Ховд аймгийн Мөнххайрхан, Дуут, Мөст, Баян-Өлгий аймгийн Алтанцөгц, Алтай, Буянт, Булган, Ногоон нуур, Сагсай суманд оршин сууж байна.



Алтайн урианхайчууд нь ан агнуур, мал аж ахуй эрхлэн амьдардаг ба тэдний эх хэл аман уламжлалын илэрхийлэл болон язгуур урлагийн ай савд “баатарлагийн түүль” голлох байр суурийг эзэлнэ.

Урианхайн “Баян цагаан өвгөн”, “Талын хар бодон”, “Бужин Даваа хаан”, “Наран хөвүүн хаан”, “Аргил цагаан өвгөн”, “Бурхан хар баатар”, “Хүдэр алтан дөш”, “Хан Харангуй” зэрэг олон туульс нь Монгол ардын аман зохиолын шилдэг дурсгал төдийгүй ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийн жагсаалтад 2010 онд бүртгэгдсэн бахархалт өв, соёл юм.

Тууль нь зөвхөн үгийн урлаг төдийгүй хөгжим аялгуу, туульчийн хайлах, хэлэх уран чадвар, ёс жаяг, зан үйлийг багтаасан нийлмэл урлагийн цогц үзэгдэл гэж үздэг. Туулийн гол үй явдал, өгүүлэмжид нүүдэлчин ард түмний эртний ахуй амьдрал, хүмүүс сайн сайхан, энх тунх байхын хүслэнг тод томруун, уран сайхнаар дүрсэлсэн байдаг.

Монголчууд төрийн их ёслол, найр хурим, эрийн гурван наадам хийх, хүүхдийн үс авах, хүүхдэд нэр өгөх, шинэ гэр барих, ан ав, аян дайнд мордох, уул овоо тахих зэрэг нийтийг хамарсан зан үйл, ёслолын үед үйлс бүтэмжтэй байх, хойчийн сайн сайхан бэлгэдлийг зөгнөж тууль хайлуулдаг уламжлалтай.



Монгол улсын Ерөнхийлөгч Х.Баттулга “Монгол баатарлаг туульсаа дээдлэн дэлгэрүүлэх тухай” 2019 оны 13 дугаар зарлигтаа, ... жил бүрийн Цагаан сарын баярыг тохиолдуулан хаврын тэргүүн сарын шинийн гуравны өдөр, мөн Монгол бахархлын өдрийг тохиолдуулан өвлийн тэргүүн сарын шинийн гурваны өдөр Төрийн ёслол хүндэтгэлийн өргөөнд баатарлаг туульсыг хайлж байх, туульсаа бүртгэн судлах, олон улсад таниулан сурталчлахыг уриалжээ.

Урианхайчуудын дунд ан авын холбоотой зан үйл, байгаль, эх дэлхийтэйгээ харилцах, мэдлэг арга ухааны төрлийн их өв соёл хадгалагдан үлдсэн төдийгүй хурим найр, элгэн төрөл болох, ахмад настан, бэрийг хүндлэх ёс нь өнөөг хүртэл хадгалагдан уламжлан үлджээ.

Баруун Монголчуудын олон угсаатны дотроос зөвхөн Алтайн урианхайчууд өөрсдийн онцлог сурын харвааг язгуураар нь өнөөг хүртэл өвлөн уламжилж ирсэн ба тэд жил бүр цагаан сарын засал болгож, муу муухайг хөөн зайлуулах бэлгэдлээр сур харваачдыг айл, саахалтаараа ээлж дараалан урьж, сурын харвааг зохион байгуулдаг байна.

Алтайн тува. Өнөөгийн Монгол улсад амьдарч буй тувачууд нь манай улсын угсаатны олон бүлгүүдийн нэгэн хэсэг, баруун монголчуудын угсаа соёлын хүрээнд нийт монгол угсаатны үндэсний соёлын сан хөмрөгийг өөрийн өвөрмөц соёлоороо баяжуулан зохих хувь нэмрээ оруулж байна.

Эдүгээ тувачууд хэмээн нэрлэгдэж буй ард түмэн ОХУ-ын Тувагийн Бүгд Найрамдах Улс, БНХАУ-ын Шинжаан Уйгарын Өөртөө засах орны Алтай аймаг, Монгол улсад тус тус аж төрж байна. ОХУ-ын тувачууд нь хуучнаар Тагнын тува, Шинжааны болон Монгол улсын тувачууд нь Алтайн тувачууд юм.

Алтайн тувачууд 1207 онд Зүчи ойн иргэдийг оруулсан болон Чингис хааны баруун зүгт дайлсан түүхэн үйл явдалтай холбогдон Тагнын тувагаас тасран салж, Алтайд нутаглан Алтайн монгол урианхайчуудтай нэгэн захиргаанд оржээ. Тэр цагаас хойш баруун монголчуудын бүрэлдэхүүнд багтаж Манжийн эрхшээлийн үед Алтайн урианхайн долоон хошуунд, Олноо Өргөгдсөн Монгол Улсын үед Дөрвөдийн баруун гарын Үнэн зоригт хан аймагт, 1927 оноос Чандмань уулын аймагт, 1931 онд Ховд аймагт, 1940 онд Баян-Өлгий аймаг байгуулагдахад Цэнгэлхайрхан сумын нэртэйгээр, түүний дараа Цэнгэл сум болон өөрчлөгдөж эдүгээ хүртэл энэ газраа амьдран сууж байгаа талаар түүхч, доктор Б.Баатархүү “Монгол Улсын Тувачууд” номондоо дурджээ.

Тувачуудын аж ахуйн үндсэн хэлбэр нь мал мал аж ахуй юм. Тэдний мал аж ахуйгаа эрхлэх арга ажиллагаа, холбогдох зан заншил, зан үйл нь бусад монголчууд, ялангуяа хөрш зэргэлдээ орших Алтайн урианхай, захчин, дөрвөд, баяд, торгууд, мянгадтай нийтлэг шинжтэй. Тэд Алтайн нурууны нэлээд өндөрлөг хэсэг Таван богд хавиар нутаглах бөгөөд байгаль цаг ууртайгаа уялдуулан сарлаг маллаж иржээ.

Тувачууд цагаан сард зориулсан мах шүүсний хонио “сангийн мал” гэдэг бөгөөд өвлийн идэш бэлтгэх үеэр төхөөрдөг. Мөн цагаан сар тэмдэглэхийн бэлтгэл болгон өвлийн сүүл сарын 29-ний өдөр гэр орноо цэвэрлэхийн зэрэгцээ гэрээсээ өмнө зүгт 70 орчим алхам газарт балан буюу балин хэмээх хааш хаашаа нэг метр орчим өрөн, 1.5 метр орчим өндөртэй чулуун овоо буюу индэр засаж, балингийн дөрвөн талд нь сан тавих гурав гурван жижиг чулуу бэлдэнэ. Үүнийгээ Алтайн 13 сан гэнэ. Балингаас чанх урагш үүд хоймрын зайд хэдэн чулуу давхарлаж тавих ба түүнийгээ “Хаан төрийн сүлдний овоо” буюу төрийн сүлдний сан гэнэ. Мөн балингийн урд талд гал түлэх чулуун тавцан бэлдэнэ. Балин, сангийнхаа тэнд шинийн нэгний өглөө ёслолоо үйлддэг. Овоондоо очингуутаа эхлээд олон салаа бургас хатгаж жалама буюу залам уяна. Энэ нь цэнхэр (тэнгэрийг бэлгэднэ), ногоон (газар), цагаан (сүү) гурван даавууны цуулдас юм. Овоонд эрчүүд, хүүхдүүд очих ба гэрийн эзэгтэй очдоггүй ёстой. Гэрт үлдсэн эмэгтэйчүүд гурван өнгийн даавууны аль нэгийг хашаа хороо, эцэг малдаа зүүж чимэглэдэг. Овоонд бэлдсэн чулуун тавцан дээрээ их гал түлж, айл болгон хонины өвчүүг залмаар ороож, хормойтой нь шатаана. Өвчүү шатаадаг ёс баруун монголчуудын дунд түгээмэл ажээ. Тэднийхээр бол Алтайн эзэн нь эмэгтэй дүртэй бөгөөд түүнд эмэгтэй хүний хувь мах болох өвчүүг ийнхүү шатааж өргөдөг ёстой ажээ. Өвчүү шатаахтай зэрэгцэн Алтайн 13 сангаа тавьж, цай, цагаан идээ, цацлын махыг шөлтэй нь хамт, архийг сүүтэй хольж нар зөв тойрч цацал болгон өргөдөг. Ийнхүү балинд буюу төрийн сүлдэнд мөргөхийг халхчууд Эзэн сүлдэнд сөргөх, баруун монголчууд Индэрт мөргөх, Дээр мөргөх, Балинд мөргөх гэх мэтчилэн нэрлэдэг ба гүйцэтгэх зан үйлийн хувьд нилээд төстэй. Мөргөл хийсний дараа ширдгээ дэвсэн ахмад настнаа суулгаад бусад нь эрэмбийн дагуу золгоцгооно. Овоон дээр цай идээнээс уусны дараа гэр гэртээ орцгоож овоонд очоогүй хүмүүстэйгээ золгоно. Тувачууд монголчуудын их эртний уламжлал ёсоор цагаан даавуу буюу цагаан хадаг барин золгодог байжээ.

Байгаль, эх дэлхийдээ хүндлэл үзүүлэх, уул овоогоо тахих энэхүү Монгол зан үйл нь хүмүүс эрт дээр үеэс газар ус, мод ургамал, ан амьтдыг харж ханддаг, ивээж тэтгэдэг эзэнтэй байдаг хэмээн сүсэлж бишрэн, тэрхүү эздийг нь газар усны эзэн лус савдаг хэмээн тэднийг урин залж, идээ ундааныхаа дээжээр тахил өргөл өргөн, аргадан баясгахын учрыг агуулсан эртний бөгөөд хамгийн түгээмэл ёслол юм.

“Уул овоо тахих Монгол зан үйл” өвийг ЮНЕСКО-ийн Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад 2017 онд бүртгэсэн. Энд яаралтай хамгаалах гэдэг үгийг маш сайн анхаарах хэрэгтэй юм. Даяаршлын нөлөөгөөр байгаль орчин бохирдон доройтож, биологийн төрөл зүйл устаж үгүй болж, дэлхийн усны нөөц хомсдож, бидний хайрлан хамгаалж ирсэн тахилгат ариун дагшин газрууд хүний буруутай үйл ажиллагаанаас болж байгаль, соёлын

өвд ихээхэн сөрөг нөлөө үзүүлэх болсон. Өнөөдөр байгаль дэлхийгээ хайрлан хамгаалахын ач холбогдол нь дэлхий нийтийн анхаарлын төвд байна. Тахилгат газар нь нэг талаас байгалийн онгон дархан газар, нөгөө талаас ард түмний дунд урт хугацаанд уламжлагдан хадгалагдаж ирсэн соёлын өв, ёс заншил, зан үйл зэргийг өөртөө агуулж байдаг. Иймээс “Уул овоо тахих Монгол зан үйл” нь байгаль, соёлын хосолсон чухал өвийн илэрхийлэл гэж хэлж болно.



22-р зураг.

Уул овоо тахих Монгол зан үйл өвийн батламж

Тувачуудын уламжлалт хуримын зан үйл, баяр цэнгэл тоглоом наадгай, ардын дуу, аман зохиол, шүтлэг бишрэл зэрэг оюуны соёлын үндсэн хэсэг нь Ойрад монголын олон угсаатнаас төдий л өөрцгүй нийтлэг эртний монголчуудын шүтлэгийн уламжлал хадгалагдан үлдсэн байна. Тухайлбал, галын шүтлэг буюу галын ширээс хийх зан үйл юм. Мөн тэд эдүгээ болтол зөвхөн нуман тамгаа хэрэглэдэг.

Алтайн тувачууд нь тува, монгол, казах хэлээр ярьдаг, монголчуудтай угсаа-соёлын эртний холбоотой, Ойрад монголын бүрэлдэхүүн хэсэг, ахуй соёлын хувьд монголжсон түрэг хэлт ард түмэн юм.

Соёлын биет бус өв. Хэдийгээр Дэлхийн өв гэх ойлголтод ихэвчлэн соёлын биет өв болох түүх, соёлын үл хөдлөх дурсгал, байгалийн дурсгалт газар нутаг багтдаг боловч тэдгээр өвийн газарт соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч

угсаатны бүлэг, хамт олон, бүлэг хүмүүс олон үеийг дамжин суурьшаар өөрсдийн зан заншил, уламжлал зан үйлээ байгаль, газар сав шим ертөнцтэйгөө уялдуулан үйлдэж амьдарсаар байгаа тул ЮНЕСКО болон түүний гишүүн улсууд байгаль, соёлын биет болон биет бус өвийг нэгэн цогц болгон авч үзэх хандлага нэмэгдэж байна.

Соёлын биет бус өв нь хамт олон, бүлэг хүмүүс, зарим тохиолдолд хувь хүний соёлын өвийнхөө бүрэлдэхүүн хэсэг гэж хүлээн зөвшөөрсөн зан үйлүүд, үзүүлж харуулах, илэрхийлэх урлаг, арга үйлдлүүд, мэдлэг болон арга ухаан, тэдгээртэй холбоотой эд өлгийн зүйл, зэмсэг, урлагийн бүтээл, соёлын орон зайг хамарсан өргөн хүрээтэй ойлголт, ухагдахуун юм.

ЮНЕСКО-ийн тодорхойлсноор Соёлын биет бус өв нь:

1. Эх хэл, аман зохиолын уламжлал;
2. Язгуур урлаг, түүний тоглож үзүүлэх, илэрхийлэх хэлбэрүүд;
3. Зан үйл, ёс заншил, баяр наадам;
4. Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг ухаан;
5. Уламжлалт урлал гэсэн үндсэн таван ай савд хамаарсан тоолж баршгүй төрөл зүйл, элементээр асар баялаг өв юм.

Монгол улс нь Нэгдсэн үндэстний байгууллага, түүний төрөлжсөн байгууллага болох ЮНЕСКО-ийн гишүүн, түүний батлан хэрэгжүүлж буй соёл, соёлын өвийн талаарх конвенцуудад нэгдэн орж үйл ажиллагаа явуулж буйн хувьд тэдгээр олон улсын гэрээ болон Монгол улсын хуулийн тодорхойлолт, заалтыг удирдлага болгон 2018 онд анх удаа “Соёлын биет бус өвийн их наадам”-ыг үндэсний хэмжээнд зохион байгуулсан юм.

Энэхүү их наадмын хүрээнд “Соёлын биет бус өвийн их наадам”-ын I шатны шалгаруулалтад Баян-Өлгий аймгийн 13 сумын 140 өвлөн уламжлагч оролцсноос хамгийн олон өвлөн уламжлагч оролцсон ай сав нь ардын язгуур урлаг, уламжлалт гар урлалын төрлүүд байв.

Баян-Өлгий аймгийн урлаачид 23 төрлийн 500 орчим бүтээл үзүүлснээс, казах, урианхай, тувагийн дээл, малгай, гутал, сэвгэр дээл, ширдэг, казах, тува гэрийн дээвэр, туурга, бүс, хошлон, зээг, доторх хэрэглэл, модны үндсээр хийсэн аяга таваг, шанага, айргийн хөхүүр, төмөр, ясан эдлэл, казах хөөрөг, морины тоног хэрэгсэл, тоглоом наадам, бүргэдийн эдлэл хэрэглэл, цоор, домбор, икэл, ой саулам –ай (шавар хөгжим/, сизеырнай хөгжим, монгол үндэсний хөгжмүүд, төмөр хуур гэх мэтийг дурдаж болно. Урианхай, тува, казах түмний дунд гар урлал хэрэглээний байдлаас урлагийн тал руугаа түлхүү хөгжиж соёлын аялал жуулчлалын бүтээгдэхүүн болж буй нь сайшаалтай хэмээн дүгнэжээ.

Шалгаруулалт наадмын хөтөлбөрт орсон ардын дуунууд, казахын айтыс, ерөөл, магтаал, Аксахалын ерөөл, урианхайн гэрийн ерөөл, сурын ерөөл, зан үйлийн дуу, казахын бэр буулгах жар жар, беташар, урианхайн дээж өргөх

дуу, бэр мордуулах дуу, охин цайлах дуу урианхай, тува, казах бий нь баруун монгол ардын язгуур урлагийн төрөл зүйл баялаг бөгөөд язгуур хэв шинжээрээ уламжлагдан байгааг харуулав.

Мөн монгол, казах, тува нар харилцан бие биеэсээ суралцаж, соёлын биет бус өвийн төрөл зүйлийг өөр өөрийн соёлын хөрсөнд буулгаж, баяжуулж байгаа нь харагдав. Тухайлбал, казахын олбогийн хээ хуараас санаа авч урианхайчууд ямааны арьсаар монгол хээ гарган олбог урласан нь маш гайхалтай хийцтэй байдаг.

3.2 АРХЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ТОЙМ (БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ)

Монгол орны алс баруун хязгаарт орших Баян-Өлгий аймгийн нутаг нь түүх, археологийн дурсгалаар нэн баялаг юм. Баян-Өлгий аймгийн нутагт анх 1876-1878 онд Төв Азийг судлаач, нэрт эрдэмтэн Г.Н.Потанин Алтайн уулс, Баруун Монголоор судалгааны ажил гүйцэтгэх үедээ одоогийн Баян-Өлгий аймгийн нутаг Даян нуурын хөвөөнд буй өвөрмөц сонин хийцтэй хүн чулуу, түүний ойролцоох хүн чулуу болон буган хөшөө зэрэг бусад дурсгалууд, Завхан аймгийн Алдархаан сумын нутаг Мөнгөт хясаа хэмээх газарт буй дөрвөн хүний сийлмэл дүрстэй хөшөө зэргийг судлан тодорхойлж гар зургийг үйлдсэнээр эхэлсэн бололтой.

Үүнээс хойш завсарлаад байсан археологийн судалгааг 1957 онд Н.Сэр-Оджав ахлагчтай шинжилгээний анги үргэлжлүүлэн явуулсан байна. Тус шинжилгээний анги нь Увс, Баян-Өлгий, Завхан аймгийн нутгаар эртний судлалын хайгуул хийж, хуучин, шинэ чулуун зэвсгийн дурсгалууд, хадны зураг, сийлбэр, бүр хожуу үеийн зарим зүйлсийг нэмэн тэмдэглэж авах зорилготой ажилласан бөгөөд судалгааны явцад дурдсан нутгуудаас эртний түрэгийн үед холбогдох 26 хүн чулуу олж Баян-Өлгий аймгийн Улаан Хус сумын Даян нуурын Күй хэмээх газарт буй 1 хүн чулуу зэргийг онцлон тодорхойлж өгүүлсэн байна.

Монгол Алтайн уулсын бүс нутагт чулуун зэвсгийн үеийн дурсгалыг илрүүлэн судлах ажил 1960-аад оны дунд үеэс эхэлжээ. 1966 онд Монгол-Зөвлөлтийн хамтарсан чулуун зэвсгийн судлах анги Монголын талаас Н.Сэр-Оджав, Д.Дорж, Зөвлөлтийн талаас А.П.Окладников (экспедицийн удирдагч), В.Волков, А.П.Деревянко, В.И.Жилковский, В.Е.Ларичев нарын бүрэлдэхүүнтэй Баян-Өлгий аймгийн нутагт ажилласан бөгөөд Өлгий хотоос судалгааны ажлаа эхэлсэн байна. 1966 оны экспедицийн үр дүнд Монгол Алтайн баруун хэсэгт чулуун зэвсгийн үеийн сонгодог хэлбэрийн хайрган зэвсэг бүхий анчид өргөн тархан амьдарч байсныг илрүүлсэн байна. 1968 онд Баян-Өлгий аймгийн нутгаар ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс археологийн судалгаа хийх тусгай анги томилон ажиллуулсны үр дүнд Алтайн их нуруугаар урьд өмнө илэрч судлагдаагүй олон

тооны археологийн дурсгал илрүүлсний дотор 14 хүн чулуун хөшөөг бүртгэн, заримынх нь гар зургийг хавсаргаж, тэдгээрт холбогдох он цаг, утга бэлгэдлийн талаар өгүүлсэн байдаг.

1983 онд Баян-Өлгий аймгийн чулуун зэвсгийн үеийг судлах ажлыг Монгол-Зөвлөлтийн түүх, соёлын хамтарсан экспедиц үргэлжлүүлсэн. Тус экспедиц Ташантаас Өлгий хот, мөн Өлгий хот орчим гэсэн чиглэлээр судалгаа хийсэн. Ингээд Сагсай, Өмнө гол, Хар ус нуур, Даян нуурын бүс нутагт 30 орчим чулуун зэвсгийн суурин дурсгалт газар нээн илрүүлжээ. 1984 онд дээрх экспедиц судалгааны ажлаа Баян-Өлгий аймагт үргэлжлүүлэн ажиллаж олон тооны эрдэм шинжилгээний чухал олдвор илрүүлсэн байна.

Баян-Өлгий аймгийн археологийн карт зохиох хайгуул шинжилгээний анги Д.Баяр, Д.Эрдэнэбаатар нарын бүрэлдэхүүнтэйгээр 1989-1990 онд ажилласан бөгөөд тус аймгийн 12 сумын нутаг болон аймгийн төв зэрэг газраар хайгуул судалгаа хийж түүхэн өөр цаг үед холбогдох олон тооны дурсгал бүртгэн тэмдэглэжээ. 1994-2001 онд Д.Цэвээндорж, Э.Якобсон, Д.Кубарев нарын удирдсан Америк, Монгол, Оросын хамтарсан "Алтай" төслийн судалгааны явцад Монгол Алтайн нурууны Хар Ямаа, Цагаан салаа, Бага Ойгорын хадны зургийг анх илрүүлжээ.

2004 оны зун Оросын ШУА-ийн Сибирийн салбарын Археологи, этнографийн хүрээлэнгийн Баруун Сибирийн археологийн отряд, Монголын ШУА-ийн Археологийн хүрээлэн, Германы Археологийн хүрээлэнгийн хамтарсан хээрийн шинжилгээний анги академич В.И.Молодин, профессор Д.Цэвээндорж нарын удирдлагаар Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутаг Ойгор гол болон түүний цутгалан Олон нуурын гол, Үнхэлцэг, Дунд Ойгор гол, Төгөс хөл зэрэг газарт Пазырыкийн булшийг илрүүлэх хайгуулын ажил хийжээ.

2005 оны зун Монгол, Францын хамтарсан археологийн "Евразиа" төслийн хээрийн шинжилгээний анги Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутаг Хурган нуурын урд бие Бага Түргэний голын зүүн гар талд Пазырыкийн үеийн гурван булшийг малтан судалсан байна.

2006 онд Герман, Монгол, Оросын хамтарсан олон улсын хээрийн шинжилгээний анги нь Монголын баруун хойд хэсэг болох Баян-Өлгий аймгийн нутаг Алтайн ууланд иж бүрэн судалгаагаа үргэлжлүүлэн дөрвөн булшийг малтан судалсан байна. Олон гүүрийн гол 6, 10-р оршуулгын газрууд нь одоогоор судлагдсан пазырыкийн соёлд хамаарагдах дурсгалуудын өмнөд хязгаарт оршиж байна.

БСШУЯ-ны захиалгаар 2005-2007 онд хэрэгжүүлсэн "Монгол Алтайн баруун хэсгийн түүх археологийн дурсгалууд" төслийн хүрээнд Баян-Өлгий аймгийн бүх сумдын нутгийг хамарсан археологийн хайгуул судалгаа хийжээ. Судалгааны ажлын үр дүнд 1500 орчим цогцолбор дурсгалд байх 8000 дурсгалыг

баримтжуулсан бөгөөд судалгааны үр дүнг “Монгол Алтайн археологийн дурсгалууд I. Баян-Өлгий аймаг” хэмээх нэгэн сэдэвт бүтээл болгон хэвлүүлжээ.

3.3 ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛУУД

Баян-Өлгий аймгийн нутгаас чулуун зэвсгийн доод шатнаас XIX-XX зууны эхэн үеийн сүм хийдийн туурь, бичээс зэрэг түүхийн бүх үеийн дурсгалууд илэрч олдсон байна. Тухайлбал, 2015 онд явуулсан Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг тооллогоор нийт 824 дурсгалт газрын 5150 дурсгал хамрагдсан байдаг.


Түүнчлэн тухайн бүс нутагт сүүлийн жилүүдэд археологийн судалгааг олон улсын хамтарсан болон үндэсний судалгааны багууд идэвхтэй хийж, шинээр олон арван дурсгалуудыг нэмж илрүүлэн судалсаар байгаа бөгөөд бүртгэл судалгаа нь сайжирсаар байна.

Чулуун зэвсгийн дурсгалт газрууд. Тус аймгийн нутаг нь чулуун зэвсгийн бүх үеийн дурсгалуудаар баялаг ажээ. Хэдийгээр зорилго чиглэлтэй малтлага судалгаа хараахан хийгдээгүй боловч тус аймгийн нутаг дэвсгэрийн үндсэн хэсгүүдэд нэн эрт үеэс хүн амьдарч байсан 79 газар илрээд байна. Ялангуяа доод чулуун зэвсгийн үеийн Алтанцөгц сумын нутаг дахь гурван дурсгал Монгол Алтайн хамгийн эртний дурсгалуудын тоонд багтаж, Монголын төдийгүй нийт Төв Азид хүн амьдарч эхэлсэн цаг хугацаа, тэдний тархалт суурьшлыг судлахад чухал байр суурь эзэлж байна.

Доод ба дунд палеолитын үеийн дурсгалууд. Нийт чулуун зэвсгийн дурсгалт газруудаас доод палеолитын үед холбогдох дурсгал зөвхөн 3 байна. Эдгээр нь Алтанцөгц сумын нутагт орших Алтанцөгц (өвлийн төв), Олон нуур-1, Олон нуур-2 болно. Дээрх дурсгалууд хоорондоо 30 км зайтай оршино. Мөсөн голын нөлөөгөөр өргөн талбайд тархаж, харьцангуй дор газарт зөөгдсөн байдаг.


Дээд палеолитын үеийн дурсгалууд. Нийт чулуун зэвсгийн дурсгалт газруудаас дээд палеолитын үеийн 32 дурсгал байна. Эдгээрийн дотроос хамгийн олон эдлэл түүвэрлэсэн, зэвсгийн шинж байдал, төрхийг бүрэн харуулж чадах “жишиг” дурсгалууд бол Ногооннуур сумын Ховд-14, Алтанцөгц сумын Улаанхус, Баяннуур сумын Баяннуур-13 болно. Зэвсгийн төрөл зүйлийн хувьд хусуур, хасуур, хянгар, шүдэрхэг зэвсгүүд, хутга, гилбэр зэрэг болно.

Мезолит-Неолитын үеийн дурсгалууд. Нийт чулуун зэвсгийн дурсгалт газруудаас Мезолит-Неолитын үеийн 20 дурсгал илэрчээ. Эдгээр нь Сагсай голын хөндий, Хар ус нуурын хотгорт голлон тархжээ. Дурсгалуудын талбай жижиг хэмжээтэй, хадархаг хошуу, асганы ойролцоо, голын хөндий, эртний нуурын эрэг хөвөө газарт оршдог онцлогтой. Түүвэрлэсэн эдлэлийн дотор зэвсгийн эзлэх хувь бусадтай харьцуулахад өндөр байгаагаас үзэхэд түр зуурын бууцнууд байсан бололтой. Монгол Алтай ба Орос Алтай мезолит неолитын



23-р зураг.

Баян-Өлгий аймгийн нутагт бүртгэгдсэн Түүх, соёлын үл хөдлөх дурсгалууд



Сагсай гол-11-ийн дурсгалууд.

Сагсай голын хөндийн дурсгалууд.

25-р зураг.

Баян-Өлгий аймгийн нутгаас олдсон чулуун зэвсгүүд

үед соёлын нэг бүс нутаг болж байсныг үгүйсгэх аргагүй. Мөн Дорнод Саяны дурсгалуудтай зарим талаар төсөөтэй байна хэмээн судлаачид дүгнэсэн байна.

Хиргисүүр. Хүрлийн үед холбогдох, Төв Азийн археологийн үндсэн дурсгалын нэг бол хиргисүүр юм. Баян-Өлгий аймгийн нутагт хийсэн бүртгэл



26-р зураг.

Хуурай говийн хиргисүүр, Улаанхус сум, Баян-Өлгий аймаг

судалгаагаар 34 дурсгалт газар 100 гаруй хиргисүүр бүртгэгдсэн байдаг бол судлаачдын тоолж бүртгэснээр 297 газар 2325 хиргисүүр байна гэсэн тооцоо бий. Энэ бүс нутгийн хиргисүүр нь их, бага гол мөрөн, нуурын ай сав, хөндийд ихэвчлэн цогц бүлэг байдлаар орших боловч уул, гүвээний суга, завсар, бэл, шил дээр ганц нэгээр тохиолдоно.

Буган чулуун хөшөө. Буган хөшөө бол Монгол болон Төв Азийн нутаг дэвсгэр дээр хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үед оршин сууж байсан овог аймгийн түүх соёлын гайхамшигтай дурсгалын нэг билээ.

Гонзгой урт чулууг засч, гурав зааглан, оройн хэсэгт нар сар, доогуур нь олон эгнээ хонхор, эх биеийг ороолгон төв хэсэгт сүрэг бугыг загварчилсан байдалтайгаар ихэд сүрлэг сийлж, бас доогуур нь бүс татан зэр зэвсгийг зүүсэн байдалтай дүрсэлсэн хөшөө чулууг буган хөшөө хэмээн нэрлэдэг.

ШУА-ын Түүх, археологийн хүрээлэнгийн судлаачид 86 газар 153 буган чулуун хөшөөний бүртгэлийг шинэчлэн хийсэн байна. Тэдгээрийн дотор хамгийн өндөр тархацтай нь Булган (42 хөшөө - 28%), Цэнгэл (32 хөшөө - 21%), Сагсай (22 хөшөө - 15%), Алтай (14 хөшөө - 9%), Дэлүүн (11 хөшөө - 8%) сум бол Буянт (2 хөшөө), Баяннуур (1 хөшөө) сумдад маш цөөн тархжээ.



27-р зураг.

Цагаан голын буган хөшөө, Цэнгэл сум, Баян-Өлгий аймаг

Энэхүү бүртгэлд хамрагдсан буган чулуун хөшөөд нь аймгийн газар нутгийн хойд, зүүн болон зүүн өмнөд хэсэгт харьцангуй цөөн, бусад хэсэгт ерөнхийдөө жигд тархсан ба ихэвчлэн томоохон гол, нуурын сав хөндийгөөр байрласан байна.

Түүнчлэн Цэнгэл сумын нутаг Цагаан голын Улаан үзүүр хэмээх газар орших хоёр буган хөшөө нь хүний нүүр дүрсэлсэн ховор тохиолдох дурсгал болно. Хүний нүүрний дүрслэлтэй буган хөшөө одоогоор монгол болон түүний хөрш бүс нутгаас 10 орчим олджээ. Буган хөшөөнд хүний нүүр дүрсэлсэн нь энэ дурсгал эрт цагт хүнийг төлөөлүүлэн үйлдсэн гэдгийг нотолсон баримт юм. Мөн Цагаан голын Улаан үзүүрийн хоёр буган чулуун хөшөөг судлаачид анх босгосон газартаа олон мянган жил хэвээрээ байгаа хэмээн үздэг бөгөөд энэ нь тухайн дурсгал болон нийт буган чулуун хөшөөний байрлал зүйг судлах чухал хэрэглэгдэхүүн болох юм.


Хадны зураг. Монгол нутагт амьдарч байсан хүрлийн үеийн овог аймгийн гишүүдийн оюун санааны хөгжлийг харуулах өөр нэгэн томоохон дурсгал бол хадны сийлмэл дурсгал юм. Ийм төрлийн дурсгал монгол нутгийн хад чулуунд харьцангуй олон тоотой байдаг төдийгүй нэгэн хаднаа өөр өөр үеийн дурсгалууд ч давхарлагдан зурагдаж холилдсон байдаг.

Баян-Өлгий аймгийн нутагт одоогийн байдлаар нийт 61 газарт хадны зураг тэмдэглэгдсэн байна. Эдгээр хадны зургууд чулуун зэвсгийн үеэс хүрэл, төмрийн түрүү үе, түрэгийн үед хамаарч байна.

Хадны сийлмэл зургийг чулуунд ямарваа нэгэн тусгай багажийн (чулуу, төмөрлөг) тусламжтайгаар хүн, мал, амьтан, тамга тэмдгийн дүрсийг цоолборлон сийлж зурсан зургууд багтана. Монгол орны нутаг дэвсгэрээс илэрч олдсон сийлмэл зургууд нь ихэвчлэн хүрэл, төмрийн түрүү үед холбогддог. Бодит байдлаар ерөнхийлөн дүрсэлсэн хүн, ан амьтад, тэрэг болон бусад дүрслэлийг хүрлийн үед холбогдуулан үзэж болох бөгөөд харин амьтныг гоёмсог байдлаар болон загварчлан урласан нь хүрлийн сүүл төмөр зэвсгийн түрүү үед холбогдоно. Мөн түүнчлэн хүннү, түрэг, монголын үед холбогдох хадны зураг харьцангуй цөөн тоотой тохиолдоно. Монгол орны нутагт буй хадны зураг бүхий дурсгалт газруудад тухайн үеийн амьтны аймгийн хамгийн гол төлөөлөгчид, эртний овог аймгуудын өдөр тутмын амьдралын салшгүй хэсэг болох мал хариулах, ан ав хийх зэрэг үзэгдлүүд тусгалаа олсон байдаг. Мөн үр удмаа үлдээх, үржиж олшрохыг бэлгэдсэн хүмүүсийн хурьцаж буй, мал амьтны нийллэгийн дүрслэл, янз бүрийн тамга тэмдэг, домгийн амьтад, шүтлэг бишрэлтэй холбоотой зураг ч бас цөөнгүй тохиолдоно. Иймээс эртний хүмүүсийн үлдээсэн хадны зургийн утга санаа, эрхэлж байсан аж ахуйн талаар сэргээн тодруулахад хадны зургийг төрөл зүйлээр нь сэдэвчлэн ангилах нь чухал ач холбогдолтой юм. Үүнд:

1. ан амьтдын сэдэвт

НЕОЛИТ-ЭНЕОЛИТ ХҮРЭЛ ЗЭВСГИЙН ҮЕ ТӨМРИЙН ТҮРҮҮ ҮЕ ЭРТНИЙ УЛСУУДЫН ҮЕ




28-р зураг.

Хадны зургийн он цаг, дүрслэлийг харьцуулсан хүснэгт (Н.Батболд, 2014)

2. аж ахуйн сэдэвт (хүний үйл ажиллагаатай холбоотой зургууд)
3. шүтлэг бишрэл, оршуулгын зан үйлийн сэдэвт
4. тамга тэмдэг
5. тодорхой бус дүрслэлүүд багтана.

Төмрийн түрүү үеийн дурсгал – Пазырыкийн булш

Монголын түрүү төмрийн үеийн голлох археологийн соёлын нэг нь Пазырыкийн соёл юм. Уг соёл нь НТӨ VI-III зуунд холбогдох бөгөөд тухайн үед Евразийн тал нутагт бие биетэйгээ зэрэгцэн оршиж байсан адил төстэй нүүдэлчдийн олон соёлын хамт Скиф, Сибирийн ертөнцийн бүрдэл хэсэг болдог.



29-р зураг.

Пазырыкийн булшны тархалтын зураг (Д.Батсүх, 2016)

Манай улсад Пазырыкийн соёлын булш оршуулгын хайгуул судалгаа 2004 оноос эхлэлтэй бөгөөд судлаачдын хийсэн бүртгэлээр Баян-Өлгий аймгийн нутагт 76 газарт 362 Пазырыкийн соёлын булш бүртгэгдсэн байна. Харин анхны малтлагыг 2005 онд Монгол, Францын хамтарсан “Евразиа” төслийн судалгааны баг Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын Бага Түргэний гол-1 дурсгалд хийж гурван булшийг судалжээ. Улмаар 2006 онд Герман, Монгол, Оросын хамтарсан төслийн баг Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Олон гүүрийн голд Пазырыкийн соёлын хоёр булш малтсаны нэг нь маш сайн хадгалалттай мөнх цэвдгийн булш байсан бөгөөд онц сонирхолтой олон арван эд өлгийн зүйлс илрүүлсэн нь дэлхийн хэмжээнд алдаршсан байдаг.

Пазырыкийн булшинд олон арван сонирхолтой эд өлгийн зүйлс дагалдуулан тавьдаг. Ялангуяа Монгол Алтайн өндөр уулын хөндийнүүдэд байх мөнх цэвдгийн нөлөөтэй орчинд органик эдлэлүүд, түүний дотор нэхмэл эдлэл, мод ба арьс, үс, ширэн эдлэл хадгалагдан үлджээ. Тэдгээр олдворууд үндсэндээ Пазырыкийн булшнаас гардаг хэв шинжит олдворууд байх боловч Монголын хувьд Пазырыкийн соёлын дунд давхаргын хүмүүсийн амьдрал, аж ахуй, соёл, зан заншлыг харуулах анхны томоохон цуглуулгыг бүрдүүлж байгаагаар ач холбогдолтой юм. Булшнаас шавар ваар сав, модон таваг, аяга, хувцас хэрэглэл, чимэглэлийн модон хэсгүүд, тухайлбал, малгайн чимэглэлийн модон сийлбэр дүрсүүд, бүсний сийлбэртэй тоногууд, адуу малын хэрэгслийн чимэглэлийн модон сийлбэрүүд, зэр зэвсгийн зүйлс гардаг. Пазырыкийн булшнаас бид түрүү төмрийн үеийн эртний нүүдэлчдийн урлагийг илүү бүрэн төгсөөр харж чаддагийн учир нь жирийн булшинд тэр бүр хадгалагддаггүй органик биетүүд зөвхөн мөнх цэвдгийн Пазырыкийн булшинд хадгалагдсан байдагт оршино.



Зураг 9. Дайчин эрийн дээлийг гарвага, хонины арьсаар хийж булганы арьсаар чимэглэжээ.
Хэмжээ: Урт 110 см

Abb. 9. Der Mantel des Kriegers bestand aus Mummeltier- und Schafsfell und war mit Zobelpelz verziert.
Maße: H 110 cm

30-р зураг.
Улаанхус сумын
Олон гүүрийн голын 10-р
булшнаас олдсон эртний
анчны арьсан дээл
(Ц.Төрбат, Д.Цэвээндорж,
2016 он)

Тухайлбал, Улаанхус сумын Олон гүүрийн голын 10-р булшнаас эртний анчин хүний эдлэж хэрэглэж байсан арьс, эсгийгээр хийсэн дээл хувцас бүхий олдворыг шинжлэх ухааны үнэ цэн, иж бүрэн, ховор нандин зэрэг түүх, соёлын өндөр ач холбогдлыг нь үнэлэн хамгаалалтад авчээ. Уг арьсан дээл нь Монгол


улсын түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлсийн жагсаалтын 566 дугаарт бүртгэгдсэн байна.

Хүн чулуу

Хүн чулуут цогцолбор босгох нь тэнгэрт халин одсон өндөр өвөг дээдсийнхээ алдар гавьяаг үеийн үед мөнхжүүлэн шүтэн тахил тайлгын шинжтэй, нүүдэлчдийн бөө мөргөлийн шүтлэг бишрэлийн нэгэн хэсэг болох ажээ. Хүн чулууг бүтээхдээ уг хүний амьд ахуйн дүр төрхийг аль болох үнэн зөв дүрслэхийг зорьж, өмсөж эдэлж байсан хувцас хэрэглэлийг нь байсан байдлаар нь цоолборлон урладаг байжээ. Тиймээс эдгээр дурсгал нь тухайн үеийн хүмүүсийн дүр төрх, эдийн соёлын шинж чанар, нийгмийн харилцааны тусгал болохоос гадна түүхийг сэргээн судлахад чухал ач холбогдолтой юм. Манай улсын нутаг дэвсгэрээс хүрлийн үе, түрэг, уйгур, хятан, монголын үеийн хүн чулуун хөшөөд илэрч олдсоор байна.

Түрэгийн хүн чулуу

Эртний түрэгүүд нас барагсдаа булшлан оршуулахын зэрэгцээ тэдний сүнсийг амаржуулах зорилгоор олноор цуглан тахил тайлгын зан үйл гүйцэтгэх онгоны газрыг тусад нь байгуулдаг байжээ. Эдгээр нь уг нас барсан хүний язгуур угсаа, зэрэг дэвээс шалтгаалан их бага, янз бүрийн хэмжээтэйгээс гадна бүтэц зохион байгуулалтаараа ч эрс ялгаатай.



31-р зураг.

Шивээт хайрханы хүн чулуун хөшөөд

Түрэгийн тайлгын онгоны нэг бүрэлдэхүүн хэсэг болох хүн чулуун хөшөө нь тухайн үеийн хүмүүсийн төрх байдал, хувцас өмсгөл, эд хэрэглэл, гоёл чимэг, зэр зэвсгийн төрөл зүйл, тэдгээрийн онцлог зэргийг сэргээн тодруулж судлахад онцгой ач холбогдолтой эх сурвалж баримт төдийгүй тэр үеийн дүрслэх урлагийн хөгжил, гоо сайхны үзлийн хэмжээ түвшинг илтгэн харуулдаг байна.

Баян-Өлгий аймгийн нутагт элбэг тохиолдох дурсгал бол Түрэгийн үеийн хүн чулуун хөшөө бөгөөд судалгааны бүртгэлд 177 хамрагдсан байна.

Эдгээрийн дотор хийц, дүслэлийн хувьд энэ үеийн хүн чулуудаас гоц ялгарах хэд хэдэн дурсгал бий. Тухайлбал, Улаан хус сумын нутаг Хар ямаатын хүн чулуу, Сагсай сумын Даян нуурын эрэгт орших “Даян баатарын хөшөө” хэмээх чулуун хөшөөд юм.

Хар ямаатын хүн чулуу

Тус хүн чулуун нь Хар Ямаатын голын хойд эрэгт, нимгэн хавтгай чулуудыг ирмэглэн суулгаж үйлдсэн дөрвөлжин хашлагын зүүн талд нүүрээрээ зүүн урагш хандан газарт зоолттой байна. Хашлагын хэмжээ 446х460 см бөгөөд дунд талын зайг үйрмэг чулуугаар дүүргэжээ. Хүн чулуунаас зүүн урагш 150 метрийн зайд 21 ширхэг чулууг зэллүүлэн зоож тавьсан нь эхлээд шулуун чиглэлтэй байснаа баруун гар тийш яльгүй дугуйрч ирээд үзүүр нь зүүн тийш эргэжээ.



Хүн чулууг цайвар, судалтай хөх өнгийн нимгэвтэр хавтгай занар чулуугаар босоо хүний ерөнхий дүр оруулан урлажээ. Хөлийн дүрс байхгүй, толгойн дээд хэсэг гэмтсэнээс малгайтай эсэх нь тодорхойгүй, бүтэн үлдсэн хэсгийг харахад өргөн шанаатай, шувтан урт эрүүтэй бөгөөд уруулын дээгүүр үзүүрийг дээш махийлган эргүүлсэн живэр, эрүүнд нь тал бүр тийш сэрвийсэн сахал гаргажээ.

Баруун гараа хагас нугалан хэвлийн өмнө дэрвэгэрдүү амсар, цүлхэн бөөр, бөөрөнхий ёроолтой жижиг ваар барьж, зүүн гараар цээжний өмнө махир үзүүртэй чинжаал хутгыг үзүүрээр нь дээш харуулан атгажээ. Түрэгийн хүн чулуунд чинжаал хутга, ваар сав дүрслэх нь ердийн үзэгдэл боловч хутгыг хуйнаас сугалж далайсан байдлаар хийсэн нь урьд өмнө тохиолдоогүй сонин дүрслэлтэй юм. Цээжин биед дээлийн энгэр заам гаргаагүй боловч хоёр мөр, тохойн дээр тус бүр нижгээд дугуйрсан зураас гарган хээлж, хоёр гарын

тохойноос дээш үргэлжлэх зураасыг үргэлжлүүлэн цээжний голд гурвалжин хэлбэр гарган нийлүүлжээ.

Хонхор чулуун зураасаар нарийн бүс гарган уг бүснээс хоёр оосроор зүүлтэй чагтан балтаг бүхий шулуун илд, түүнтэй зэрэгцүүлэн дээгүүрээ цүлхэн хэлбэртэй саадгийг гурван оосроор зүүлгэн дүрсэлжээ. Энэ хөшөөний хамгийн сонирхолтой дүрслэвэр нь бүсэлхийнээс доошх хэсэгт буй эмээл хазаартай хоёр морийг цулбуураас нь хөтлөн сөхөрч суусан хоёр хүний дүрс юм. Морь, хүн тус бүрийг өөд өөдөөс нь харуулан сольбуулж дүрсэлсэн ба дээд талын морь, хүн хоёрын дунд хоорондоо хоёр дүрс буйн нэг нь хөвчлөөгүй нум, нөгөө нь саадаг бололтой. Хоёр морины нуруунд эмээлийн бүүрэг тодорхой мэдэгдэх бөгөөд морьд нь жижгэвтэр толгойтой, зэгзгэр урт хөлтэй, газар шүргэсэн урт сүүлтэй ажээ.

Хар Ямаатын хөшөө нь хэлбэр хийц, дүрсэлж гаргасан эд юмсынхаа загвараар VI-VIII зууны Түрэгийн үеийн соёлын дурсгал болох нь тодорхой төдийгүй Монголд өөр ч хаана ч байхгүй онцгой сонин дүрслэлтэй хүн чулуу хэмээн үздэг.

Даян баатарын хөшөө

Тус хүн чулуун хөшөө одоо байгаа байдлаар 160 см өндөр, 40 см өргөн, 20 см зузаан хэмжээтэй цайвар боржин чулуун уг хөшөөнд хүний толгой, их биеийг дүрсэлсэн боловч гар хөлийг дүрслээгүй байна. Тэгэхдээ малгай, ээмэг бүхий чих, нүд, хөмсөг, хамар, ам, живэр сахал тэр ч байтугай хацрын төвгөрийг хүртэл нарийн гаргажээ. Их биед мөрөвч, бүс, хувцасны эмжээр чимэглэл гэмээр 2 см өргөнтэй нарийн товгор зураас үргэлжлүүлэн товойлгож гаргажээ. Хүзүүнд сахиус бололтой дэвж буй шувуу хэлбэрийн зүйлийг зүүлт болгосон байна. Зүүн хойшоо 72 градусын чиглэлд хандуулж босгосон хөшөөний баруун хойд талд 4х4 м хэмжээтэй цайвар боржин хашлага хийсэн нь өдгөө бүтэн байна. Зарим судлаачид Даян баатарын хөшөөнд дүрсэлсэн сахиусны хэлбэрийг МЭ-ий VI-VIII зууны эртний Түрэг угсааны аймгуудын дунд христос шашин дэлгэрч байсантай, зарим нь эртний түрэг-монгол угсааны овог аймгуудын дунд өргөн түгсэн эхийн умай шүтлэгийн ёстой холбон янз бүрээр тайлбарладаг.



33-р зураг.

"Даян баатар" хэмээх хүн чулуун хөшөө

Уйгурын үеийн хүн чулуун хөшөөд

Монгол нутагт илэрч олдсон хүн чулуун хөшөөдийн ихэнх нь хийсэн арга барил, загвар, дүрслэл хийгээд дүрсэлж гаргасан эд юмсын хувьд эртний Түрэгийн үед холбогдож байгаа нь нотлогдсон. Хэдий тийм боловч эдгээрийн дотор үндсэн шинж тэмдгүүдээр өмнөх үеийн нийтлэг загвараас эрс ялгаатай цөөн тооны хүн чулуун хөшөө бий.

Ийм өвөрмөц хэлбэр дүрслэлийн хүн чулуун хөшөө манай орны баруун бүс нутаг буюу Баян-Өлгий аймгийн Сагсай сумын Бага хайрга, Улаан дэлийн үзүүр, Битүү болон Баяннуур сумын Цагаан хөшөөт, Ногооннуур сумын төвд буй зэрэг хүн чулуун хөшөөдийг нэрлэж болно. Энэ төрлийн хүн чулуун хөшөөдөд дүрслэн гаргасан эд зүйлс гэвэл, олонх нь хоёр чихэвчийг нь дээш сөхөж



34-р зураг.

Битүүгийн хүн чулуун хөшөө

өмссөн өвөрмөц хэлбэрийн малгайтай, гарт барьсан савны хэлбэр нь ердөө л ганц төрөл байхаас гадна түүнийгээ хоёр гараараа гэдэсний өмнө барьсан, эр хүнийг дүрсэлсэн хөшөөнд ганц бүдүүн гээг болон олон унжлага зүүлт бүхий цулгүй бүс заавал байдаг зэрэг шинж болно. Зарим судлаачид энэ төрлийн дурсгалын он цаг, учир холбогдол нарийн гүйцэд тогтоогдоогүй байгаа ч бүтэц, зохион байгуулалт зэрэг шинж тэмдгээр нь VIII-X зууны үед холбогдуулан үздэг.

Бичээс

Баян-Өлгий аймгийн нутгаас түрэг, монгол, төвд, тод зэрэг үсгээр бичигдэн үлдсэн цөөн тооны дурсгалуудыг илрүүлэн олоод байгаа билээ. Үүнд Цагаан салаа/Бага ойгорын түрэг бичээс, Шивээт хайрханы түрэг бичээс, Эрээн харганатын түрэг бичээс, Зүрх уулын түрэг бичээс, Хар магнайн түрэг бичээс, Олон нуурын түрэг бичээс, Баяннуур сумын төвд бичээс, Ёл хадны тод бичээс зэргийг дурдаж болно.

3.4 ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛУУД

Баян-Өлгий аймгийн төв Өлгий хотод аймаг, орон нутгийн байгаль, соёлын өвийг хамгаалах, сурталчлах зорилготой аймгийн музей ажиллаж байна.

Тус музей нь "Аймгийн орон нутгийг судлах кабинет" нэртэйгээр 1948 онд суурь нь тавигдаж, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1962 оны 461 дүгээр тогтоолоор музей болж өргөжсөн билээ. Анх аймгийн захиргаанд үзмэр цуглуулах ажлыг нэг хүн давхар хариуцаж, улмаар зарим хэсэг нь нурсан лалын шашны жижиг сүмд цугласан эд өлгийн зүйлийг хадгалж байсан нь их ажлын гараа байжээ.

Шинээр байгуулсан уг аймгийн төвийг хөгжүүлэх ажил ид өрнөсөн 1962 онд МАХН-ын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга байсан Х.Мусахан нарын шилдэг сэхээтнүүд гар нийлэн Сагсайн хүрээнээс түүхий тоосго зөөн, музейн анхны барилгыг нийтийн субботникийн шугамаар барьж байгуулсан байна.

Баян-Өлгий аймгийн музей нь 1988 онд ашиглалтад орсон, орчин үеийн музейн зориулалттай гурван давхар барилгатай бөгөөд үзэгчдийн сэтгэлийг татдаг хамгийн сонирхолтой хэсэг нь угсаатны зүйн танхим байдаг. Уг танхимд байгаа казах үндэстний 6 ханатай, иж бүрдэлтэй эсгий гэрийг, хойморт нь уяатай мөнгөн эмээлийн тоноглол бүхий цагаан морийг харсан хүн хөдөөгийн нэгэн айлд зочилсонтой

адил таашаал авдаг. Түүхийн танхимд төр, нийгмийн зүтгэлтэн, улсын болон хөдөлмөрийн алдар цолтой гавьяатнуудын талаар дэлгэн үзүүлж байна.

2019 оны байдлаар музейн сан хөмрөгт 1359 дэсийн 5314 ширхэг үзмэр эд өлгийн зүйлс хадгалагдаж байгаагаас биет үзмэрийн 70 орчим хувийг дэглэлтэд байлгаж, нийтэд сурталчилдаг ба Толбо нуурын тулалдаан болон Таван богдын байгалийн хосгүй үзэсгэлэнг харуулсан диаграмм, алтан шармал эмээл, нэхий болон унаганы арьсан дээл, кебис-маси, хуримын хувцас саукеле-желек, солир чулуу, халиу, хар чоно буга, хойлог мөн бүргэдийн хэрэгсэл, коран судар, ном, тува үндэстний бөөгийн онго, урианхай ястан Хуяг дарханы урлан бүтээсэн хэт хутга, казак үндэсний модон ор, дөрвөд урианхай ястнуудын эртний хувцас, чимэг гоёл, дахин давтагдашгүй хийцтэй гэр ахуйн эдлэлүүд зэрэг нандин дурсгалууд олон бий.



35-р зураг.
Казах үндэстний эмээл
(Баян-Өлгий аймгийн музей)

4

ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖУУД

Манай улс соёлын өвийг хамгаалах тухай Монгол улсын Үндсэн хууль болон эрх зүйн бусад баримт бичгүүдэд тодорхой заасан байдаг. Тухайлбал, Монгол улсын Үндсэн хуульд: 7.1-д “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна”, Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд: 3.1.4.1-д “Монголын түүх, хэл, соёл, шашин, зан заншлыг хамгаалах, хөгжүүлэх, судлах ажлыг төр ивээлдээ авч, ном, сурах бичиг, кино урлагийн бүтээл туурвилыг онцгойлон урамшуулж, биет болон биет бус соёлын өвийг хамгаалан хөгжүүлнэ”, Монгол улсын Төрөөс баримтлах соёлын бодлогод: 4.3.2-д “Эрт эдүгээгийн соёлын өв санг үндэсний эрхэм баялаг болохын хувьд төрийн хамгаалалтад байлгах” гэх зэргээр заажээ.

Түүнчлэн соёлын өвийг хамгаалах үйл ажиллагааг зохицуулах тусгай хууль, эрх зүйн баримт бичгүүдийг 1920-иод оноос батлан, хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 1970 онд “БНМАУ-ын Соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах тухай хууль”, 1994 онд “Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль”, 2001 онд “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийг батлан мөрдөж байсан бөгөөд 2014 онд “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийг шинэчлэн найруулж батлан, одоо даган мөрдөж байгаа бөгөөд хэд хэдэн зүйл заалтыг шинээр оруулсан байна. Тухайлбал, Соёлын өвийн зэрэглэлийг өвийн төрөл тус бүрээр зааж өгсөн байдаг. Үүнд:

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалалтын түвшингээр:

- Улсын хамгаалалт /Засгийн газар/, Аймаг, нийслэлийн хамгаалалт /Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулага/,
- Сум, дүүргийн хамгаалалт /Мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн аймаг, нийслэлийн ИТХ/

Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн зэрэглэл:

- Түүх, соёлын хосгүй үнэт зэрэглэл /Засгийн газар/,

- Түүх, соёлын үнэт зэрэглэл /Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулага/,
- Түүх, соёлын ердийн зэрэглэл /хассан/

Соёлын биет бус өвийг:

- Төлөөллийн үндэсний жагсаалт,
- Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний жагсаалтад бүртгэнэ.

Мөн Соёлын өвийг хамгаалах тухай хуульд Дэлхийн өвийн талаар тусгайлан тусгасан зүйл заалтуудыг оруулсан байдаг. Үүнд:

СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ (Шинэчилсэн найруулга)

2014 оны 5 дугаар сарын 15-ны өдөр

Гуравдугаар бүлэг. Соёлын өвийн талаарх төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх

13 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

- 13.1.9. Дэлхийн өвийн үндэсний хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах;
- 13.1.13. Соёлын өвийг Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлэхээр нэр дэвшүүлэх болон Дэлхийн өвийн жагсаалтад бүртгэгдсэн соёлын өвийг хадгалж хамгаалах, өвлөн уламжлуулах, түгээн дэлгэрүүлэхтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлэх;

14 дүгээр зүйл. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

- 14.1.3. Соёлын өвийг Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлэх ажлыг зохион байгуулах, бүртгэгдсэн өвийг хадгалж хамгаалах арга хэмжээ авах; */Энэ зүйлийг 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/*

Наймдугаар бүлэг. Дурсгалт газрыг хамгаалах

42 дугаар зүйл. Соёлын өвийн дурсгалт газар

- 42.1. Улсын Их Хурал соёлын өвийн дурсгалт газрын унаган төрх, соёлын үнэт зүйлийн язгуур шинжийг хамгаалах зорилгоор тусгай хамгаалалтад авах тухай шийдвэр гаргаж, хилийн заагийг батална.
- 42.2. Соёлын өвийн дурсгалт газар байгуулах саналыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газарт өргөн мэдүүлнэ. Саналд тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг харгалзан үзэж болно.

- 42.3. Соёлын өвийн дурсгалт газарт үндэсний болон дэлхийн өвийн дурсгалт газар хамаарна.
- 42.4. Соёлын өвийн дурсгалт газрыг дараах бүсэд хуваана:
 - 42.4.1. хамгаалалтын бүс;
 - 42.4.2. орчны бүс.
- 42.5. Соёлын өвийн дурсгалт газарт хэд хэдэн түүх, соёлын дурсгалт газар байрлаж болно.
- 42.6. Хамгаалалтын болон орчны бүсэд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр байгаль, соёлын өвд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж болно.
- 42.7. Соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын менежментийг хариуцан хэрэгжүүлэх үүрэг бүхий хамгаалалтын захиргаа ажиллана.
- 42.8. Соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын захиргаа энэ хуулийн 43, 44-т заасан үйл ажиллагаатай уялдуулан нэмэлт дэглэм тогтоож болно.
- 42.9. Соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын захиргаанд хэд хэдэн дурсгалт газрын хамгаалалтын асуудлыг харьяалуулж болно.

43 дугаар зүйл. Хамгаалалтын бүсийн дэглэм

- 43.1. Хамгаалалтын бүсэд энэ хуулийн 38.1-д зааснаас гадна доор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно:
 - 43.1.1. онцгой байдал үүссэнээс бусад тохиолдолд нисэх онгоц буулгах;
 - 43.1.2. ашигт малтмал эрэх, хайх, ашиглах;
 - 43.1.3. мод, элс, хайрга, чулуу авах зэргээр байгалийн төлөв байдлыг өөрчлөх;
 - 43.1.4. хот суурин, цахилгаан станц байгуулах;
 - 43.1.5. тэсэлгээ хийх;
 - 43.1.6. шинээр барилга байгууламж барих.

44 дүгээр зүйл. Орчны бүсийн дэглэм

- 44.1. Орчны бүсэд энэ хуулийн 38.1-д зааснаас гадна доор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно:
 - 44.1.1. ашигт малтмал эрэх, хайх, ашиглах;
 - 44.1.2. хот суурин, цахилгаан станц байгуулах;
 - 44.1.3. тэсэлгээ хийх.

45 дугаар зүйл. Түүх, соёлын дурсгалт газар

- 45.1. Засгийн газар түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах, харагдах сүр барааг хадгалах зорилгоор хамгаалалтын бүс тогтооно.

- 45.2. Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 45.1-д заасны дагуу хамгаалалтын бүс тогтоосон түүх, соёлын дурсгалт газарт гэрээт харуул томилж ажиллуулна.
- 45.3. Түүх, соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүсэд энэ хуулийн 38.1-д зааснаас гадна доор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно:
- 45.3.1. газар, түүний хэвлийг хөндөх;
 - 45.3.2. мэргэжлийн байгууллагын дүгнэлтгүй мод бут, төрөл бүрийн ургамал тарих;
 - 45.3.3. гэр, сууц, барилга, байгууламж барих;
 - 45.3.4. мал бэлчээх;
 - 45.3.5. онцгой байдал үүссэнээс бусад тохиолдолд өөрөө явагч хэрэгсэл нэвтрүүлэх, нисэх онгоц буулгах;
 - 45.3.6. ашигт малтмал эрэх, хайх, ашиглах;
 - 45.3.7. мод, элс, хайрга, чулуу авах.
- 45.4. Түүх, соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүсэд судалгаа шинжилгээ хийх, сэргээн засварлах, аялал жуулчлалын зорилгоор сурталчлах үйл ажиллагаа явуулж болно.

Түүнчлэн Соёлын өвийг хамгаалах талаар Гамшгаас хамгаалах тухай хууль, Газрын тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, Ашигт малтмалын тухай зэрэг бусад салбарын хуульд мөн тусгасан байдаг.

Үүний зэрэгцээ Монгол Улсын Эрүүгийн тухай хууль болон Зөрчлийн тухай хуульд соёлын өвийн эсрэг үйл ажиллагаа, гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх талаар заажээ. Үүнд,

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ (Шинэчилсэн найруулга)

2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр

9.7 дугаар зүйл. Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих

1.Хуульд заасны дагуу:

- 1.1. соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлээгүй, эсхүл уг сангийн нууцлал, хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдал, мэдээлэл үнэн зөв, бүрэн гүйцэд, зөрүүгүй байх шаардлагыг хангаагүй;
- 1.2. соёлын өвийг хуульд заасан хугацаанд бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлээгүй;
- 1.3. соёлын өвийг зөөж тээвэрлэх журам зөрчсөн;
- 1.4. түүх, соёлын дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эд зүйлийг хурааж хүнийг нэг зуун

нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Соёлын өвийн судалгаа, шинжилгээ хийхдээ язгуур шинж, унаган төрх байдал, хүрээлэн байгаа орчны зохиомжийг эвдэж хуулиар тогтоосон журам, эсхүл стандартыг зөрчсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3. Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг худалдах анхны саналыг төрд тавихгүйгээр худалдсан, эсхүл гадаад улсын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүний өмчлөлд шилжүүлсэн, эсхүл зуучилсан бол уг дурсгалт зүйлийг хураан авч улсын орлого болгон хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
4. Соёлын биет өвийг сэргээн засварлах хуулиар тогтоосон журам, эсхүл стандартыг зөрчсөн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
5. Соёлын биет өвийг хадгалах, хамгаалах, ашиглах талаар хуулиар тогтоосон хориглолт, журам, стандартыг зөрчсөн, эсхүл анхны төрх, нэгдмэл цогц байдлыг алдагдуулсан, эсхүл зөвшөөрөлгүй хөдөлгөж, зөөж тээвэрлэсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
6. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын дэргэд байрлуулсан танилцуулга, тайлбар, тэмдэг, тэмдэглэгээг эвдэж устгасан, эсхүл дурсгал дээр ханын самбар, зурагт хуудас, түүнтэй адилтгах бусад хэрэгслийг байрлуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
7. Соёлын өвийн, эсхүл түүх, соёлын дурсгалт газрын хамгаалалтын дэглэм зөрчсөн бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
8. Газрын хэвлийг эзэмших, ашиглах явцад илэрсэн соёлын биет өвийг хамгаалах, мэдээлэх арга хэмжээ аваагүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
9. Нийтийн өмчийн соёлын биет өвийг 1:1 масштабаар зөвшөөрөлгүй хувиран олшруулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг нэг

мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10. Палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийхдээ:

10.1. геологийн ховор илэрц, эрдэсжилтийн онцгой тогтоц, усны эх, рашаан, булаг, бүрд зэрэг байгалийн унаган тогтоц, эмзэг хэсгийг гэмтээсэн;

10.2. тэсэрч дэлбэрэх бодис хэрэглэсэн;

10.3. судалгааны үр дүнд хохирол учруулж болзошгүй техник, тоног төхөөрөмж ашигласан;

10.4. малтлага, судалгааны явцад үүссэн нүх, хонхор болон хүрээлэн байгаа орчны үзэмжийг эвдсэн элс, шороо, чулуун овоолго үлдээсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

11. Түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдол бүхий олдворыг хадгалах, хамгаалах, судлахдаа түүний анхны төрх байдал, хэлбэр, шинж чанарыг алдагдуулж гэмтээсэн, олдворыг стандартын шаардлага хангаагүй өрөө тасалгаа, орчинд хадгалсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

12. Соёлын биет өвийг сурталчлах, судалгаа, шинжилгээ хийх, сургалт явуулах зориулалтаар ашиглахдаа гэмтээсэн, эсхүл үрэгдүүлсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

13. Соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын болон орчны бүсэд хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

14. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлээгүй палеонтологи, археологийн олдвор, дурсгалаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үзэсгэлэн гаргасан, эсхүл музей байгуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хураан авч улсын орлого болгож хүнийг зургаан зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг зургаан мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно

7.17 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутагт хориглосон үйл ажиллагаа явуулах

2. Тусгай хамгаалалттай газар нутагт хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол,

нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

ЭРҮҮГИЙН ХУУЛЬ **(Шинэчилсэн найруулга)**

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр

ХОРИН ТАВДУГААР БҮЛЭГ

Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг

25.2 дугаар зүйл. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг эвдэх, гэмтээх, устгах

1. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг санаатай эвдсэн, гэмтээсэн, устгасан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

2. Улс, орон нутгийн хамгаалалтад авсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг санаатай эвдсэн, гэмтээсэн, устгасан, эсхүл энэ гэмт хэргийг олон хүний амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулж болох аргаар үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

25.4 дүгээр зүйл. Хууль бусаар археологи, палеонтологийн хайгуул, малтлага хийх

1. Хууль бусаар археологи, палеонтологийн хайгуул, малтлага, судалгаа хийсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

2. Хууль бус археологи, палеонтологийн хайгуул, малтлага, судалгааг санхүүжүүлсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
3. Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

25.5 дугаар зүйл. Соёлын биет өвийн хууль бус худалдааг зохион байгуулах, зуучлах

1. Соёлын биет өвийн худалдааг хууль бусаар явуулсан, зуучилсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
2. Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
3. Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

/Энэ хэсгийг 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

25.6 дугаар зүйл. Түүх, соёлын дурсгалт зүйлийг тогтоосон хугацаанд хилээр оруулж ирэхгүй байх

1. Түүх, соёлын дурсгалт зүйлийг хуулиар тогтоосон журмын дагуу тогтоосон хугацаанд улсын хилээр оруулж ирээгүй бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/
2. Түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлийг хуулиар тогтоосон журмын дагуу тогтоосон хугацаанд улсын хилээр оруулж ирээгүй, эсхүл түүх, соёлын дурсгалт зүйлийг завшсан бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ ХУУЛЬ

1994 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр

12 дугаар зүйл. Дархан цаазат газарт хориглох үйл ажиллагаа

- 1/ газар хагалах, ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, элс, хайрга чулуу авах, мод, зэгс, шагшуурга бэлтгэх, хязгаарлалтын бүсээс бусад газарт зам тавих зэргээр байгалийн төлөв байдлыг өөрчлөх;
- 2/ байгалийн дагалт баялаг, эмийн, хүнсний болон техникийн зориулалттай ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх;
- 3/ Ан амьтны тооллого, тэдгээрийн тоо, нас, хүйс, сүргийн бүтцийг зохицуулах үйл ажиллагааг батлагдсан хөтөлбөр, аргачлалын дагуу явуулах, зааснаас өөр зориулалтаар ан амьтан агнах, барих, үргээх, тэдгээрийн үүр, ичээ, нүх, ноохойг хөндөх, эвдэж сүйтгэх;
- 4/ хортон шавьж, мэрэгчид, түймэртэй тэмцэх, тэдгээрээс сэргийлэх арга хэмжээнд байгаль орчинд сөрөг нөлөөлөх арга, техник, бодис хэрэглэх;
- 5/ аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтаар зохих журмын дагуу барьсан орон байрыг ашиглахаас өөр барилга байгууламж барих;
- 6/ хөрс, ус, агаар бохирдуулах аливаа үйл ажиллагаа явуулах;
- 7/ тухайн газрын хамгаалалтын захиргааны зөвшөөрөлгүйгээр нохой дагуулж, буу авч явах;
- 8/ аргагүйгээс бусад тохиолдолд тухайн газрын хамгаалалтын захиргаанаас урьдчилан авсан зөвшөөрөлгүйгээр агаарын хөлгөөр буулт хийх, хэт нам өндрөөр нислэг үйлдэх;
- 9/ өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн барилга байгууламж барих, зохих зөвшөөрөлгүйгээр мал бэлчээрлүүлэх;
- 10/ нуур, мөрөн, гол горхи, булаг, шанд зэрэг ил задгай усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах;
- 11/ хууль тогтоомж болон хамгаалалтын горимоор хориглосон байгаль орчинд сөрөг нөлөөлөх бусад үйл ажиллагаа явуулах.

18 дугаар зүйл. Байгалийн цогцолборт газарт хориглох үйл ажиллагаа

- 1/ энэ хуулийн 12 дугаар зүйлийн 1-8, 11-т заасан үйл ажиллагаа явуулах;
- 2/ онцгой бүсэд энэ хуулийн 12 дугаар зүйлийн 9,10-т заасан үйл ажиллагаа явуулах;
- 3/ батлагдсан ерөнхий төлөвлөгөө, зураг төсвийг зөрчиж суурингийн нутаг дэвсгэрийг тэлэх, барилга байгууламж барих.

21 дүгээр зүйл. Байгалийн нөөц газрын дэглэм

1. Байгалийн нөөц газарт хамгаалалтад авсан байгалийн хэв шинж, тодорхой баялгийн төрх байдал, ургамал, амьтны аймгийн байршил, өсөлт, үржилтэд сөрөг нөлөөгүйгээр уламжлалт аж ахуй эрхлэж болно.
2. Байгалийн нөөц газарт түүний байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй барилга байгууламж барих, үйлдвэрлэлийн зориулалтаар газар ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, ан амьтан агнах, барих, мод, зэгс, шагшуурга бэлтгэх зэргээр байгалийн унаган төрхийг өөрчлөх, голын усыг бохирдуулах аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

24 дүгээр зүйл. Дурсгалт газрын дэглэм

1. Дурсгалт газарт хаалт, хашлага барих, сэрэмжлүүлсэн дохио, тэмдэг тавих, түүний хамгаалалтыг нутгийн оршин суугчдад хариуцуулан өгөх зэргээр хамгаалалтын арга хэмжээ авна.
2. Дурсгалт газар дахь байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлээс 0,1-3,0 км-ийн орчимд сүр бараа, үзэмжийг нь дарах барилга байгууламж барих, газар хагалах, ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлийг хөндөх, эвдэх, буулгах, тэдгээрт хохирол учруулахуйц бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

ХАВСРАЛТ ЗУРАГ

МОНГОЛ АЛТАЙН НУРУУНЫ УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР
НУТГИЙН АН АМЬТАН, УРГАМАЛ





НОМ ЗҮЙ

Монгол хэлээр:

1. Б.Баатархүү, Монгол Улсын тувачууд. УБ., 2017. 446 тал
2. Н.Батболд, Монголын говийн бүсийн хадны зургийн судалгаа. УБ., 2014. 184 тал
3. Баян-Өлгий аймаг статистикийн товчоон. Боловсруулж, эмхтгэсэн: Ш.Сэржхүү, Л.Нямбат. Хянан тохиолдуулсан: Б.Эрдэнэсүрэн, С.Алтанцэцэг. УБ., 2014.
5. БОАЖЯ. Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан. УБ., 2016-2017.
6. БОАЖЯ. Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан. УБ., 2017-2018.
7. Д.Мягмарсүрэн, А.Намхай. Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгууд. УБ., 2015.
8. Ц.Жаргалсайхан Монгол угсаатан, үндэсний өв уламжлал, соёлын орон зай. УБ., 2017. 472 тал
9. Монгол Алтайн мөнх цэвдгийн булш Монголын пазырыкийн соёл. Үзэсгэлэнгийн католог. Ред. Ц.Төрбат, Д.Цэвээндорж. УБ., 2016. 136 тал
10. Монголын музейн шилдэг үзмэрийн дээжис. I боть. Ерөнхий ред: Ц.Цэндсүрэн. УБ., 2014. 398 тал
11. Монгол нутаг дахь түүх, соёлын дурсгал (Сэдэвчилсэн лавлах). УБ., 1999. 286 тал
12. Монгол ба бүс нутгийн буган хөшөөний соёл. Эрдэм шинжилгээний католог. Тэргүүн боть. Ц.Төрбат (Ред.) УБ., 2018 440 тал
13. Соёлын биет бус өвийн их наадам-2018 (Мэдээ, мэдээлэл, гэрэл зургийн цомог). Эрхлэн хэвлүүлсэн: Г.Энхбат. УБ., 2018. 148 тал
14. Ц.Төрбат, Д.Баяр, Д.Цэвээндорж, Ц.Баттулга, Н.Баярхүү, Т.Идэрхангай, П.Х.Жискар Монгол Алтайн археологийн дурсгалууд-I. Баян-Өлгий аймаг. УБ., 2009. 424 тал
15. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын лавлах. Эмхэтгэсэн Г.Энхбат, Г.Анхсанаа, Ред: Б.Цогтбаатар. УБ., 2015.
16. Н.Уртнасан, Ц.Самдан Дэлхийн болон Монголын өв соёл. УБ., 2010.
17. Д.Цэвээндорж, В.Д.Кубарев, Э.Якобсон Арал толгойн хадны зураг. УБ., 2005.
18. Д.Цэвээндорж, В.Д.Кубарев, Э.Якобсон Шивээт хайрханы хадны зураг. УБ., 2010.

19. Д.Цэвээндорж, Монгол Алтайн хадны зураг // Mongolica. Vol.I (45), Ulaanbaatar, 2012.
20. Я.Цэрэндагва, Д.Цэвээндорж, Түргэний хос толгойн хадны зураг. УБ., 2016. 430 тал
21. Ш.Шагдар, Монголын газар зүйн нэрийн товч толь бичиг. УБ., 1978.

Англи болон орос хэлээр:

1. Йозеф Аугуста., Зденек Буриан. Жизнь Древнего Человека. Артия-Прага., 1961.
2. В.Д.Кубарев, Д.Цэвээндорж, Э.Якобсон Петроглифы Цагаан-Салаа и Бага-Ойгура (Монгольский Алтай). Новосибирск: Изд-во ИАЭТ СО РАН, 2005. 640
3. В.Д.Кубарев Петроглифы Шивээт-Хайрхана (Монгольский Алтай). Новосибирск: Изд-во ИАЭТ СО РАН, 2009. 420 с.
4. Basic Texts of the 1972 World Heritage Convention. Edition October 2016. UNESCO, World Heritage Centre, 2016.
5. Jacobson E., Kubarev V., Tseevendorj D. Mongolie du nord-ouest, Tsagaan Salaa/Baga Oigor, (Mmoires de la mission archéologique française en Asie Centrale), fasc.6, 2 vol., 2001, 482 p., 1323 pictogrammes ; pl. 256 p., 12 cartes, 3 ill., 427 photo.
6. Raconte-moi le Patrimoine Mondial. UNESCO, 2002.
7. The Kit: World Heritage in Young Hands. UNESCO 2004.

